



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2021.1.11. № 53, 54

МОНГОЛБАНКНЫ
ТЭРГҮҮН ДЭД
ЕРӨНХИЙЛӨГЧ
Г.ДӨЛГӨӨН:
БАНКУУД
ХУВЬЦААТ
КОМПАНИЙН
ХЭЛБЭРТ
ШИЛЖСЭНЭЭР
ОЛОН ДАВУУ
ТАЛТАЙ



МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН
САНГААС: ТАМГАНЫ АЛТАН ЦООЖ

ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГТЭЭНД



03

ОНЦЛОХ МЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫГ
ЕВРОПЫН ХОЛБООНЫ
ХАР ЖАГСААЛТААС
ГАРГАЛАА



12

БАЙР СУУРЬ

БАНКНЫ ТУХАЙ
ХУУЛИЙН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙН
ТАЛААР



06

ЯРИЛЦЛАГА

Г.ДӨЛГӨӨН: БАНКУУД
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХЭЛБЭРТ ШИЛЖСЭНЭЭР
ОЛОН ДАВУУ ТАЛТАЙ



15

АСУУЛТ, ХАРИУЛТ

МОНГОЛБАНКНЫ
ХЭВЛЭЛИЙН БАГА
ХУРЛААС

21

НИЙТЛЭЛ

НИРГЭСЭН ХОЙНО
НЬ ХАШХИРАХ
БУС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ
ТОГТОЛЦООГ
БҮРДҮҮЛНЭ



26

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГ

ХЯТАДЫН БАНКНЫ
САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ,
ХӨГЖИЛ



24

МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ

Б.БАТБААТАР:
МОНГОЛ УЛСАД
КРИПТО ВАЛҮТЫГ
ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ
ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БИЙ
БОЛГОХООР АЖИЛЛАЖ
БАЙНА



34

БАНКИР

Б.МЭДРЭЭ: ХОЁР
ШАТЛАЛТ БАНКНЫ
ТОГТОЛЦОО
НЬ МОНГОЛЫН
НИЙГЭМ, ЭДИЙН
ЗАСГИЙН ХӨГЖИЛД
КАТАЛИЗАТОРЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭСЭН

МОНГОЛ УЛСЫГ ЕВРОПЫН ХОЛБООНЫ ХАР ЖАГСААЛТААС ГАРГАЛАА



Европын Холбооны албан ёсны сэтгүүлд Монгол Улсыг Европын Холбооны хар жагсаалт гэж нэрлэгддэг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай, өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтаас хассан тогтоолыг 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр нийтэллээ. Энэхүү тогтоол нь тус сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш 20 дахь хоногоос эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Монгол Улсыг 2019 оны 10 дугаар сард Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтад орсонтой холбогдуулан 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрөөс Европын Холбооны өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын жагсаалтад оруулаад байсан юм. Монгол Улс бусад улс орнуудтай харьцуулахад хамгийн богино хугацаанд буюу 1 жилийн дотор саарал жагсаалтаас гарч чадсан улс болсон. Иймд Европын Комиссоос Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай байдлыг Европын Холбооны 2015/849 дугаартай тогтоолын шаардлагуудын дагуу үнэлж, стратегийн дутагдлыг бүрэн арилгах шаардлагыг хангасан байна гэж дүгнэжээ.

БАНКНЫ АЖИЛТНЫГ МЭРГЭШҮҮЛЭХ “ШИНЭ ИНСТИТУТ” БАЙГУУЛАХ ГЭРЭЭНД ГАРЫН ҮСЭГ ЗУРЛАА



Монголбанк, Монголын Банкны Холбоо, ХБНГУ-ын Шпаркассэ банкны Монгол дахь сан “Хамтын ажиллагааны гэрээ”-нд гарын үсэг зурлаа. Монгол Улсын санхүүгийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх зорилтын хүрээнд Төв банкнаас төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж байгаа билээ. Тус хөтөлбөрийн хүрээнд энэхүү хамтын ажиллагааны гэрээг байгуулж байгаа бөгөөд оролцогч талууд хамтран Монгол Улсад банкны ажилтныг мэргэшүүлэх “Шинэ институт” байгуулах, банкны ажилтнуудад зориулсан стандартчилагдсан сургалт, хөтөлбөр боловсруулах, банкны мэргэжилтний онол, практик хосолсон сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх, дэлхийн хуримтлалын өдөр аяныг үргэлжлүүлж, хамрах хүрээг нь тэлэх зэрэг ажлыг хийж хэрэгжүүлэх юм. Монголбанк, ХБНГУ-ын Шпаркассэ сантай хамтран “Монгол Улсад банкны мэргэжилтэн бэлтгэх, онол практик хослуулсан сургалт болон Дэлхийн хуримтлалын өдрийг нэвтрүүлэх” төслийг 2017 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд хамтын ажиллагааны гэрээнд гарын үсэг зурснаар төслийн үр дүн, туршлагыг урт хугацаанд, тогтвортой хадгалах нөхцөлийг бүрдүүлэв.

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАВ



Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн УИХ-ын намрын ээлжит чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийг хангуулснаар банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл-удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн арилжааны банкуудад хувьцаа эзэмшил, удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдэл буурч, банкны хувьцааны эзэмшил, мэдээллийн хүртээмжээр дамжуулан олон нийтийн хяналт бий болох, зах зээлийн дохиолол бүрдэх, банкны хяналт шалгалтын бие даасан байдал нэмэгдэхээс гадна хөрөнгийн зах зээлийн хөгжилд эерэгээр нөлөөлөх олон давуу талыг бий болгоно. Цаашид банкууд хувьцаат компани болж, хөрөнгийн захад үнэт цаас гаргах тохиолдолд ил тод байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ашигт ажиллагааны тодорхой шалгуур тавих, зохистой засаглалын зарчмын шаардлага нь өргөн хүрээнд тавигдах болж байна.

“ЦАГААН-УУЛ” ДУРСГАЛЫН ЗООС ОЛОН УЛСЫН ШАГНАЛ ХҮРТЛЭЭ



ОХУ-ын “Russian Coin Constellation” 14 дэх удаагийн “Шилдэг Зоос” шалгаруулах уралдаанд улс орнуудын Төв банк, зоос үйлдвэрлэгчид нийт 9 төрөлд өрсөлдлөө. Дэлхийн томоохон нэр хүнд бүхий “Шилдэг зоос” шалгаруулалтад нийт 17 орноос 26 оролцогч 2019 онд үйлдвэрлэгдсэн 200 гаруй дурсгалын зоос ирүүлжээ. Уг шалгаруулалтад Монгол улсын “Цагаал уул” франчайз дурсгалын зоос “Шилдэг уран сайхны шийдэл” төрөлд III байрт шалгарлаа. Тус зоос нь 33 мм диаметртэй, 31,1 гр жинтэй юм. Мөн 13 дахь удаагийн “Russian Coin Constellation” 2019 оны “Шилдэг зоос” шалгаруулах уралдаанаас Монгол улсын Эрт галавын үеийн араатан цувралын “Velociraptor” франчайз зоос “Шилдэг технологи” төрөлд III байр эзэлж байжээ. Энэхүү дурсгалын зоос нь Эрт галавын үеийн араатны цувралын хамгийн анхны франчайз зоос бөгөөд 65 мм диаметртэй, 93,3 гр жинтэй юм.

БИЧИЛ, ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭГЧДЭД САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАГЧ БАГШ НАРЫГ БЭЛТГЭЛЭЭ



Монголбанк, Европын сэргээн босголт хөгжлийн банкнаас хамтран хэрэгжүүлж байгаа “Бичил жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох” сургагч багш бэлтгэх сургалтыг цахимаар амжилттай зохион байгууллаа. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн 3.3-т “иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ” гэж заасныг үндэслэн Монголбанкнаас бусад байгууллагуудтай хамтран дэд хөтөлбөр боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Энэ хүрээнд Монголбанк, ХХААХҮЯ, СЗХ, Жижиг дунд үйлдвэрийн газар, Зээлийн батлан даалтын сан, БШУЯ-ны харьяа Насан туршийн боловсролын үндэсний төв, Нийслэлийн ЖДҮ-ийг дэмжих төв, МҮХАҮТ, Монголын эмэгтэйчүүдийн холбоо зэрэг байгууллагуудын нийт 32 ажилтнууд сургагч багш бэлтгэх сургалтанд хамрагдлаа.

Сургалтыг Шпаркасэс банкны Монгол дахь сангийн суурин төлөөлөгч, мастер сургагч багш Маркус Лох, тус сангийн ажилтнууд болон Монгол Улсын эксперт багш нар хамтран зохион байгууллаа. Энэхүү сургалтаар бэлтгэгдсэн сургагч багш нар нь цаашид бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт санхүүгийн боловсрол олгох сургалтуудыг хийхээс гадна дараагийн сургагч багш нарыг бэлтгэх юм.

САНХҮҮГИЙН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ ХУРАЛДЛАА



Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-ийн 2021 оны 1 дүгээр улирлын ээлжит хурлыг 2 дугаар сарын 1-ний өдрөөс 16-ны өдрийн хооронд хоёр үе шаттайгаар зохион байгууллаа. Эхний өдрийн хурлаар Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлэхээр санаачилсан “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх цогц төлөвлөгөө”-ний хүрээнд Монгол улсын эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн саналыг боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Монголбанкны Дэд Ерөнхийлөгчөөр ахлуулан байгууллаа. Уг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци болон Зээлийн батлан даалтын сангийн төлөөлөл орж ажиллав.

СТБЗ-ийн 2 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар эдийн засгийг сэргээх хүрээнд ажлын хэсгээс боловсруулсан ажлын байрыг дэмжих зээл, ипотекийн зээл, репо санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээний саналыг хэлэлцлээ. Уг асуудлын хүрээнд Зээлийн батлан даалтын үйл ажиллагааг идэвхжүүлэх замаар аж ахуйн нэгжүүдэд хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох, уул уурхайн орд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулж эх үүсвэр бүрдүүлэн ажлын байрыг дэмжих болон хөдөө аж ахуйн салбарт олгох хүүгийн хөнгөлөлттэй зээлийг олгох, Монголбанкнаас хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн хэмжээг

нэмэгдүүлэх, мөнгөний бодлогын зорилттой уялдуулан репо санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх санал, түүнийг хэрэгжүүлэх арга механизмыг танилцууллаа. Уг арга хэмжээний саналыг СТБЗ-ийн гишүүд дэмжлээ. СТБЗ-өөс гаргасан саналыг Засгийн газрын хуралдаанд Сангийн яамнаас танилцуулж, Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгчөөр ахлуулсан хамтарсан ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтэнд нь хяналт тавихаар тогтов.

О УРТ ХУГАЦААТ РЕПО АРИЛЖАА ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Монголбанкнаас Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор урт хугацаат репо санхүүжилтийн хэрэгслийг ашиглан жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон уул уурхайн бус экспортлогчид 10.5%-ийн хүүтэй, 2 жилийн хугацаатай зээл олгох арга хэмжээг 2020 оны 4 дүгээр улиралд эхлүүлсэн. Энэ арга хэмжээний хүрээнд 2020 оны 12 дугаар сард олгосон 230 тэрбум төгрөгийн репо санхүүжилтийн эх үүсвэрийг банкууд нийт 20 мянга орчим ажилтантай 1536 аж ахуйн нэгжид шинээр зээл олгох болон зээлийг дахин санхүүжүүлэх хэлбэрээр ашиглаад байна.

Мөнгөний бодлогын хорооноос 2021 оны 1 дүгээр улиралд 250 тэрбум төгрөгийн урт хугацаат репо санхүүжилт олгохоор шийдвэрлэсний дагуу 2021 оны 2 дугаар сарын 22-ны өдөр Монголбанкнаас урт хугацаат репо арилжаагаар ирүүлсэн саналын дагуу ХААН, Худалдаа хөгжлийн, Голомт, Хас, Тээвэр хөгжлийн, Богд, Капитрон, Кредит банкуудад нийт 200 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Урт хугацаат репо санхүүжилтийн эдийн засагт үзүүлэх нөлөөг сайжруулах зорилгоор Монголбанкнаас жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг хамрагдах боломжоор хангаж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид олгох зээлийн дээд хэмжээг 3 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэв.

Цаашид банкууд Монголбанкнаас авсан санхүүжилтээр жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд болон уул уурхайн бус салбарт үйл ажиллагаа явуулдаг экспортлогч аж ахуйн нэгжүүдэд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 2 дугаар сарын 19-ны өдрийн А-58 дугаар тушаалаар батлагдсан шалгуурын дагуу 3 тэрбум төгрөг хүртэл хэмжээтэй, 2 жилийн хугацаатай, жилийн 10.5%-ийн хүүтэй зээлийг шинээр олгох болон өмнө олгосон зээлийг дахин санхүүжүүлэх юм.

О МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАСҮРЭН ОУВС-ИЙН СУУРИН ТӨЛӨӨЛӨГЧ ЮН СОК ХЁНЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн өнөөдөр /2021.02.24/ Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн Монгол дахь Суурин төлөөлөгч ноён Юн Сок Хёныг хүлээн авч уулзлаа.

Уулзалтын үеэр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн эдийн засгийн өнөөгийн төлөв байдал, цар тахлын үед Монголбанкнаас авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, үндэслэл, үр дүнтэй байдлын талаар мэдээлэл өгч, санал солилцов.

ОУВС-ийн Суурин төлөөлөгч ноён Юн Сок Хён цар тахлын энэ хүнд нөхцөлд эдийн засгийг дэмжих чиглэлд Засгийн газар, Монголбанкнаас бодлогын шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгааг онцолж, цаашид санал солилцож хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийллээ.

Г.ДӨЛГӨӨН: БАНКУУД ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХЭЛБЭРТ ШИЛЖСЭНЭЭР ОЛОН ДАВУУ ТАЛТАЙ



Банкны тухай хуулийн шинэчлэл, хуулийн үндсэн үзэл санаа, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн талаар Монголбанкны Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Г.Дөлгөөнтэй ярилцлаа.

2021 ОН ГАРСААР БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРЛОО. ҮҮНИЙ ДАГУУ БАНКНЫ САЛБАРТ ХЭД ХЭДЭН РЕФОРМ ХИЙГДЭХЭЭР БОЛООД БАЙНА. ТОМ ЗУРГААРАА ЭНЭ ХУУЛИЙН БАНКНЫ САЛБАРТ АВЧРАХ ӨӨРЧЛӨЛТИЙГ ТА ХЭРХЭН ХАРЖ, ДҮГНЭЖ БАЙГАА ВЭ, МӨН ЦАГ ХУГАЦААНЫ

ХУВЬД ХЭР НИЙЦТЭЙ, ОНОВЧТОЙ БАЙНА ВЭ?

2018 онд Банкны тухай хуулийн өөрчлөлтийн хүрээнд хуулийн 40 гаруй хувьд нь нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайн үед ОУВС-ийн хөтөлбөрийн дагуу банкуудад активын чанарын үнэлгээ хийгдээд байсан бөгөөд Банкны

тухай хуульд банкуудын удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагад тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, банкыг тогтворжуулах төлөвлөгөө, үйл ажиллагаа ба түүнд тавигдах хязгаарлалт, бүтцийн өөрчлөлтийн арга хэмжээнүүдийн талаарх заалтуудыг оруулж өгсөн. Харин энэ удаад хуулийн 15 хувьд нь

өөрчлөлт орууллаа. Энэ удаагийн өөрчлөлт нь цаг хугацааны хувьд чамгүй сорилттой үед Монгол Улсын банкны салбарын хөгжилд шинэ алхам болохуйц түвшинд хийгдсэнээрээ онцлог болж байна.

Түүх дурдвал, 1924 онд Монгол Улсад банкны систем анх үүсгэн байгуулагдсанааас хойш 70 жилийн хугацаанд улсын банкны системээр явж ирсэн. Тэр үед ганц л банкны институттай, түүгээрээ дамжуулан арилжааны төлбөр тооцоо, зээл, мөнгөний бодлого хэрэгжүүлдэг байлаа. Дараа нь 1991 онд Банкны тухай хууль батлагдаж, хоёр шатлалт банкны системтэй болсноор төв банк болон арилжааны банк бий болж, хувийн банкуудын үйл ажиллагааны зах зээл шинээр бүрэлдэн бий болсон. Үүнээс хойш 30 жилийн дараа буюу 2021 онд хоёр шатлалт банкны тогтолцоонд хөгжлийн дараагийн үе шатыг авчрах өөрчлөлт орсон гэж харж байна. Өөрөөр хэлбэл, хуулийн дагуу гол өөрчлөлт нь банкууд компанийн төлөвөө нээлттэй болон хаалттай хувьцаат компани болгож, өөрчлөх ёстой болсон. Банкууд нээлттэй хувьцаат компани болсноор ард иргэд зөвхөн хадгаламж эзэмших бус хөрөнгийн зах зээлээр дамжуулан тухайн банкны хувьцаа эзэмшигч болох боломж бүрдэнэ.

Таны дурдсанчлан цаг хугацаа нь зөв үү гэдэг асуудал бий. Энэ хуулийн төсөл боловсруулагдаад

нэлээд хугацаа өнгөрөөд байсан. Үүний дараа Их хурлаар маш идэвхтэй, олон талын хэлэлцүүлэг өрнүүлж, баталлаа. Энэ утгаараа шинэчлэлийн алхам юм. Нөгөө талаар шинэчлэл хийж байгаа учраас эрсдэл гарах нь дамжиггүй. Гэхдээ энэ бүх алхмыг төв банк маш олон судалгааны үндсэн дээр хийсэн. Тухайлбал, 2008 онд дэлхийн санхүүгийн хямрал болсныг та бүхэн мэднэ. Тухайн үед Дэлхийн банкны хийсэн судалгаагаар 100 гаруй орноос 50-аад оронд засаглалын хямрал үүссэн байна гэдгийг тодорхойлж, хязгаарлалтууд тавьж өгөх талаар зөвлөсөн байдаг. Үүний дагуу 50 гаруй улс оронд банкны салбартаа хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах, банкуудыг хувьцаат компани болгох зохицуулалтыг оруулж өгсөн байдаг юм. Бид бүхэн судалгаанд үндэслэн, 20 гаруй орон, тэр дундаа өөрсдийн эдийн засгийн бүтэцтэй ойролцоо орны жишгийг харгалзаж үзсэн. Улмаар нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийнхээ хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй хэмжээний хувийг эзэмшихээр тусгаж өгсөн.

ШИЛЖИЛТИЙН ПРОЦЕСС ДЭЭР ТӨВ БАНКНЫ ОРОЛЦОО ЯМАР ТҮВШИНД БАЙХ ВЭ?

Монгол Улсын санхүүгийн салбарын 90 гаруй хувь нь банкны салбар дээр тогтож байна. Тэгэхээр мөнгөний урсгал

нь баялаг бүтээх гэхээсээ илүү банкны салбарын пассив талд буюу хадгаламж, харилцахад төвлөрч байна. Энэ утгаараа бид орлогоо бүрдүүлсэн ч түүнийгээ дахин эргэлтэнд оруулж, бүтээн байгуулалт босгох асуудал хоцрогдолтой байна. Энэ утгаараа санхүүгийн салбарын төвлөрлийг мөн бууруулахаар эрмэлзэж байгаа. Тэгэхээр хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд төв банк нэлээд өндөр ач холбогдол өгч байгаа гэдгийг хэлмээр байна. Үүнтэй холбоотойгоор манай ажлын хэсэгт Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам орж ажиллаж, саналаа хэлж, идэвхтэй хамтран ажиллаж байна.

Банкууд хувьцаат компанийн хэлбэрт шилжээд, хувь эзэмшлийн төвлөрлөө бууруулаад эхлэхээр хөрөнгийн зах зээлийн эргэлт нэмэгдэнэ. Өнөөдрийн байдлаар хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээг харвал 3 орчим их наяд төгрөг эргэлдэж байна. Харин нийт 12 банк 3.6 орчим их наяд төгрөгийн дүрмийн сантай байна. Үүний 10 хувь гэж тооцвол 360 орчим тэрбум төгрөг болно. Аливаа компанийн бирж дээр хувьцаагаа гаргаж байгаа тохиолдолд олон улсын жишгийн дагуу хөрөнгийн үнэлгээг хөндлөнгийн этгээдээр хийлгэх ёстой. Энэ үйл ажиллагааг Үнэт цаасны тухай хууль болон холбогдох бусад хуулиудаар банкуудад нээлттэй үлдээсэн. Тэгэхээр банкууд өөрсдөө хувьцаа эзэмшигчдийн

хурлаа хийгээд, өөрсдийнхөө хөрөнгийг мэргэжлийн байгууллагуудаар үнэлүүлж, андеррайтинг хийлгэснээр IPO гаргах боломжтой. Энэ хүрээнд олон улсын сайн жишгүүд орж ирэх болов уу гэж харж байгаа.

Банкууд хэлбэрээ өөрчлөхөөр шийдвэрлэсэн эерэг мэдээллүүд гараад эхэллээ. Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлд Санхүүгийн зохицуулах хороо болон Төв банкны хамтарсан тушаалаар энэхүү арилжааг хөрөнгийн зах зээл дээр хэрхэн явуулж, зохицуулах талаарх журмыг батлахаар тусгасан. Үүнээс гадна хөрөнгө оруулалт хийх боломжийг хүн болгонд нээлттэй болгож өгснөөр дараа дараагийн зохицуулалтын асуудал гарч ирнэ. Монгол Улсын Засгийн газар, Төв банк, СЗХ, хууль хүчний байгууллагууд гээд олон байгууллагын хамтарсан ажлын уйгагүй хөдөлмөрийн үр дүнд бид өнгөрсөн онд ФАТФ-ын саарал жагсаалт болон Европын холбооны хар жагсаалтаас гарсан. Тэгэхээр мөнгөний урсгалыг нээж өгснөөрөө мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх буюу үүнтэй холбоотой асуудал гарах эрсдэлээс урьдчилан сэргийлж төв банк, СЗХ анхаарч байгаа. Тиймээс ч энэ шинэчлэлийг алхам алхмаар хийх нь зүйтэй гэж үзээд, тодорхой журам гаргахаар ажиллаж байна. ФАТФ-ын зөвлөмжүүдийн хүрээнд 20 сая төгрөгөөс дээших сэжигтэй гүйлгээнд хяналт

тавьдаг механизмтай. Үүнтэй адилаар хувьцааны арилжаан дээр иймэрхүү хяналт хэрэгтэй гэдэг үүднээс төв банк болон СЗХ хамтран зохих журмыг гаргаж, мөрдүүлэхээр ажиллаж байна.

**БАНКНЫ САЛБАР
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТ,
ТЕХНОЛОГИ, БОЛОВСОН
ХҮЧИН ГЭЭД БАРАГ
БҮХИЙ Л ЧИГЛЭЛЭЭР
МОНГОЛДОО ТЭРГҮҮЛДЭГ
ГЭХЭД ХИЛСДЭХГҮЙ.
ЭНЭ УТГААРАА ЭНЭ ТОМ
САЛБАРТ ХИЙГДЭЖ
БАЙГАА ӨӨРЧЛӨЛТ
ТОДОРХОЙ ЭРСДЭЛИЙГ
ДАГУУЛАХ БОЛОВ УУ
ГЭСЭН БОЛГООМЖЛОЛЫГ
ЗАРИМ ЭДИЙН ЗАСАГЧИД
ХЭЛЖ БАЙГАА. ТЭГЭХЭЭР
ЭРСДЭЛИЙГ ХАМГИЙН
БАГА ТҮВШИНД БАЙЛГАХ,
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХУВИЛБАРУУДЫГ ТӨВ БАНК
ХЭРХЭН ХАРЖ, ҮНЭЛЖ
БАЙГАА ВЭ?**

Өнгөрсөн хугацаанд зарим банк хувьцаат компанийн хэлбэрт шилжээд, тодорхой асуудлуудаас болж татан буулгасан туршлага байгаа. Тэдгээр банкуудад 2009 оны хямрал хүчтэй нөлөөлсөн. Энэ болон бусад шалтгаанаар уг банкуудын зохистой харьцааны голлох үзүүлэлтүүд болох төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн харьцаанууд алдагдсан. Тийм учраас эдгээр банкууд хөрөнгийн зах зээлээс мөнгө босгох сонирхлоо илэрхийлж, ашигласан байдаг. Мэдээж бид өмнөх алдаанаас суралцах ёстой. Ялангуяа энэ удаад бид бага хэмжээний мөнгө

яриагүй. Хөрөнгийн зах зээл дээр хүчтэй савлагаа үүсгэж болзошгүй их хэмжээний мөнгөний асуудал. Тэгэхээр бид үүнтэй холбоотой журмуудаа маш сайн боловсруулж, батлахаас гадна Төв банкны тухай хууль, Банкны тухай хуулийн дагуу банкуудын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалтыг нэлээд сайн хэрэгжүүлж, шалгах нь зүйтэй. Энэ хяналт шалгалтын үйл ажиллагаа өнөөдөр ч бас явагдаж байгаа. Өнгөрсөн жилүүдэд Монголбанкны хяналт шалгалт “Базел-3” руу шилжих шилжилтийнхээ бэлтгэл ажлыг нэлээд сайн хангасан. Ялангуяа банкуудын өөрийн хөрөнгө дээр нөөц сангуудыг хангалттай бүрдүүлж өгсөн. Өнөөдрийг хүртэл банкууд Ковид-19 цар тахал буюу үүнээс үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийг даван туулж байгаа нь энэхүү нөөц сангуудыг сайн бүрдүүлсэнтэй ч холбоотой. Тэгэхээр банкуудын санхүүгийн чадавх, эрүүл мэндийг сайжруулсан энэ үр дүнг бататгаснаар хувьцаат компанийн хэлбэрт шилжих процесс илүү тогтвортой явна.

Нөгөө талдаа иргэд маань илүү санхүүгийн сахилга баттай, санхүүгийн боловсролоо нэмэгдүүлэх шаардлага тулгарна. Хувьцаанд хөрөнгө оруулж байгаагийн хувьд банкны санхүүгийн тайланг уншчихдаг, зах зээл дээрх үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг харчихдаг байж сая худалдаж авсан хувьцаагаа зөв үнэлж, түүнээсээ

өгөөж хүртэх боломж бүрдэнэ. Яагаад гэвэл та хувьцаа худалдан авснаараа тухайн банкны харилцагч бус, эздийнх нь нэг болж байгаа. Банкинд асуудал үүсвэл та харилцагчийн хувиар бус эзний хувиар хариуцлагыг хуваалцах болно гэдгийг бид маш сайн ойлгох хэрэгтэй. Тэгэхээр хүмүүс сахилга баттай болж, аль банкны хувьцааг авбал илүү өгөөжтэй вэ, аль банкны үйл ажиллагаа доголдсон байна вэ гэдгийг өдөр тутмын сонин, хэвлэл болон веб сайт дээр нь тавигдсан аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангаас нь харчихдаг болно. Энэ нь нөгөөтээгүүр хөрөнгө оруулалт гэсэн санхүүгийн бүтээгдэхүүнээс гадна банкны үйл ажиллагааг ойлгох боломжийг иргэдэд өгөх юм.

ЭНЭ ҮЕД ХӨРӨНГИЙН ЗАХЫН СУУРЬ ХЭР ХАНГАЛТТАЙ БАЙГАА ВЭ?

Хөрөнгийн зах зээл бэлэн эсэхэд эргэлзэхгүй байна. Дэлгүүрээр жишвэл, дэлгүүрийн лангуу, барилга байгууламж нь байна. Тодорхой түвшинд туршлага, боловсон хүчин нь байна. Хөрөнгийн захад үйлчилгээ, зуучлал үзүүлдэг үнэт цаасны компаниуд байгаа. Тэгэхээр энэ зах зээл шинэ биш. Банкууд орж ирснээр энэ дэлгүүрийн лангуун дээр шинэ бүтээгдэхүүнүүд гарах давуу талтай. Энэ нь хөрөнгийн бирж дээр нэлээд эерэг өөрчлөлтийг авчирж, зах зээлийг хөгжүүлэхэд томоохон түлхэц болох болов уу.

Цаашдаа хөрөнгийн зах зээл дээрх бүтээгдэхүүнүүд нэмэгдэж, тэдгээр нь илүү чанартай, найдвартай болсноор ард иргэдэд хүрэх өгөөжийг ахиулах ёстой. Бид бүхэн мөнгөө хадгалуулахаас гадна сайн компанид хөрөнгө оруулж, үр ашгаа хүртэж байвал сая санхүүгийн боловсролтой болж байна гэсэн үг. Аливаа мөнгийг хадгалахаас гадна тодорхой хэсгийг нь бүтээн байгуулалт болох хөрөнгө оруулалтад байршуулах шаардлагатай. Банкууд дээр 17 их наяд төгрөгийн хадгаламж байршиж байгаа. Энэ бол чамлахааргүй үзүүлэлт. Зах зээл дээр эргэлдэж байгаа мөнгө зээл хэлбэрээр нийлүүлэгдэхээс гадна хөрөнгө оруулалт болох, улмаар бизнес явуулахад нааштай, эерэг орчныг бүрдүүлэхэд чиглэх боломж бүрдэж байна.

АЛИВАА ШИНЭЧЛЭЛ, РЕФОРМ БҮХИЙ Л ТАЛД АШИГ ТУСАА ӨГЧ БАЙХ ЁСТОЙ. НЭГ ТАЛААС АРД ИРГЭД ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ БОЛСНООР ҮР АШГАА ХҮРТЭНЭ. ЭНЭ НЬ НИЙТ САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛДЭЭ ЭЕРЭГЭЭР НӨЛӨӨЛНӨ. ХАРИН БАНКУУД ЭНЭ ӨӨРЧЛӨЛТӨӨС ЯМАР ЭЕРЭГ ЗҮЙЛСИЙГ ӨӨРСӨДӨӨ БИЙ БОЛГОЖ ЧАДАХ БОЛ?

Бид энэ хуулийн өөрчлөлт дээр Банкны холбоотой нэлээд хамтарч ажилласан. Банкны холбоо нь банкны гүйцэтгэх удирдлагуудыг төлөөллөөс

бүрддэг. Банкны эзэд банкны дотоод үйл ажиллагаанд шууд оролцох ёсгүй. Энэ нь компанийн хуулиар ч тэр, олон улсын жишигт ч байдаг зүйл. Тэгэхээр банкны удирдлагуудын хувьд үүн дээр нэлээд нааштай хандаж байгаа. Олон санал, санаачилгуудыг ч ирүүлсэн.

Тэгэхээр банкны хууль хэрэгжиж эхэлснээр банкууд ард иргэдэд нээлттэй болж эхэлнэ. Энэ бол гол үзэл санаа, концепц нь. Улмаар иргэд банкуудын үйл ажиллагааг маш сайн мэддэг болоод зогсохгүй банкны хувьцаа эзэмшигч болсноор өөрсдөө хяналт тавьдаг болно. Төв банкны тухай хууль болон Банкны тухай хуулийн зохицуулалтаар ил тод, нээлттэй байх зарчмыг ихээхэн нэмэгдүүлсэн. Иргэдээс мөнгө татан төвлөрүүлж, санхүүгийн зуучлалыг үзүүлж байгаа гэдэг утгаараа банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдал нь олон нийтэд байнга ил байх ёстой. Энэ том мөнгөний урсгал дээр координац, санхүүгийн зуучлалыг хийж байгаа гол этгээд нь банк учраас энэ институтын үйл ажиллагаа маш эрүүл, нээлттэй байвал зохино. Нөгөө талдаа хөрөнгө оруулалт хийх харилцагчдын идэвх нэмэгдсэнээр банкуудад бий болох нэг томоохон эерэг зүйл нь өөрийн хөрөнгийн хүрэлцээ нэмэгдэж байгаа явдал юм. Энэ нь тухайн банкны актив өсөх боломжуудыг нээж өгнө. Мөн зах зээл дээр өрсөлдөөн,

“ Түүх дурдвал, 1924 онд Монгол Улсад банкны систем анх үүсгэн байгуулагдсанаас хойш 70 жилийн хугацаанд улсын банкны системээр явж ирсэн. Тэр үед ганц л банкны институцтэй, түүгээрээ дамжуулан арилжааны төлбөр тооцоо, зээл, мөнгөний бодлого хэрэгжүүлдэг байлаа. Дараа нь 1991 онд Банкны тухай хууль батлагдаж, хоёр шатлалт банкны системтэй болсноор төв банк болон арилжааны банк бий болж, хувийн банкуудын үйл ажиллагааны зах зээл шинээр бүрэлдэн бий болсон. Үүнээс хойш 30 жилийн дараа буюу 2021 онд хоёр шатлалт банкны тогтолцоонд хөгжлийн дараагийн үе шатыг авчрах өөрчлөлт орсон гэж харж байна.

”

олон нийтийн дунд нэр хүндээ алдахаас сэргийлэх хандлагыг төлөвшүүлнэ.

Цар тахлын хүнд үеийг бид даван туулаад багагүй хугацаа өнгөрлөө. Бид бүхэн олон улсын нөхцөл байдлуудыг маш анхааралтай ажиглаж байна. Цаашдаа улс орнууд юунд анхаарч, бэлдэж байгаа вэ гэдгийг ч харж байгаа. Энэ хүндрэлийг даван туулах, цаашид эдийн засгийг сэргээхэд төв банкуудын оролцоо их байгаа нь тодорхой. Манай төв банк цар тахлын дараах нөхцөл байдлыг яаж харж байна вэ, юунд бэлдэж байна вэ. Иргэдийн хувьд зөвхөн төв банк гэлтгүй нэлэнхүйд нь их шүүмжлэлтэйгээр хандаж байна?

Монголбанкнаас өнгөрсөн 1 жил гаруйн хугацаанд бодлогын олон шийдвэрүүдийг гаргалаа. Эдгээр арга хэмжээнүүд нь нэг талаас санхүүгийн зуучлалыг тасалдуулахгүй байх, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэж байсан бол нөгөө талаас хүндрээд байгаа эдийн засгийг тогтворжуулах, улмаар дэмжихэд чиглэсэн. Зарим шийдвэрүүд илүү макро эдийн засгийн шинжтэй том дүр зургаар харвал үр дүн нь харагдахаар байгаа бол зарим шийдвэрүүд нь иргэд, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд шууд нөлөөлөх, зээлийн зохицуулалтын арга хэмжээнүүд байв. Ард иргэдийн өрийн дарамтыг бууруулах, аж ахуй нэгжүүд зээлээ төлж чадахгүй байх нөхцөлд хүрэх вий гэдгээс

урьдчилан сэргийлэх зорилгоор хэд хэдэн бодлогын шийдвэр гаргасан. Тухайлбал, бодлогын хүүг 6 хувь буюу түүхэн доод түвшинд хүргэсэн. Энэ нь банкууд дээр богино хугацаандаа орлого, зарлагын хувьд нэлээд цохилт болж байгаа. Цаашид инфляцын болон ханшийн эрсдэл, зардал талаас бодлогын хүүг бууруулах орон зай хязгаарлагдмал юм. Улс орон бүрийн мөнгөний бодлого нь өөрийн загварчлал төсөөлөл дээр үндэслэдэг болохыг дурдах нь зүйтэй. Энэ загварчлал дээр мөнгөний бодлогын зах зээлд дамжих хоцрогдлыг нэмбэл хүүг буулгаснаар хүрэх ахиу үр дүн төдийлөн харагдахгүй байгаа.

Нөгөөтээгүүр дан ганц бодлогын хүүнээс гадна бусад хэрэгслүүдийг ашиглах боломж нь бидэнд нээлттэй байна. Үүний нэг нь урт хугацаат репо санхүүжилт юм. Банкууд нөөц хөрөнгөө төв банкны үнэт цаасанд байршуулаад байна. Хэдий 6 хувь болтол бууруулсан ч гэсэн тэдний хувьд эрсдэлээс зайлсхийх үүднээс зээл олгохоос илүү зардалтай байгаа хэдий ч төв банкны үнэт цаасыг авч байгаа. Нөгөө талдаа зээл олгоё гэсэн ч харилцагчид шинээр зээл авах бус одоо байгаа өрийн дарамтыг бууруулах хүсэлтүүдийг банкуудад түлхүү ирүүлж байна. Энэ бүгдээс бид дүгнэлт хийснээр төв банк мөнгөний бодлогын бусад арга хэрэгслүүдийг ашиглахаар тогтсон. Урт хугацаатай репо санхүүжилтаар

2020 онд 230 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг банкуудад олгосон. Энэ эх үүсвэрийг нийт 20 мянга орчим ажилтантай 1536 аж ахуйн нэгжид шинээр зээл олгох болон зээлийг дахин санхүүжүүлэх хэлбэрээр ашиглаад байна. Улмаар 2021 он гарснаас хойш 2 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар Монголбанкнаас урт хугацаат репо арилжаагаар ирүүлсэн саналын дагуу банкуудад нийт 200 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олголоо.

Түүнчлэн, иргэд аж ахуй нэгжийн зээлийн өрийн дарамтыг бууруулах зорилгоор актив ангиллын журамд өөрчлөлт оруулснаар зээлийн хүү болон үндсэн төлбөрт өөрчлөлт оруулах боломжийг нээж өгсөн. Мөн хэрэглээний болон төрөөс хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй нөхцөлтэй ипотекийн зээлийг 7 дугаар сарын 1 хүртэл хойшлуулсан. Ипотекийн зээлийн хувьд хүү хуримтлуулахгүй буюу энэ зардлыг төв банк, Засгийн газар хүлээн авахаар болсон.

Ер нь бүх асуудлын углуурга нь цар тахал шүү дээ. Тэгэхлээр вакцин орж ирж, эрүүл мэндийн чиглэлээр ахиц гарч байгаатай зэрэгцэн, хүндрээд байгаа эдийн засгийг тэтгэх зайлшгүй шаардлагатай байна. 2020 онд эдийн засаг 5.4 хувиар агшаад байгаагийн дээр төсвийн алдагдал 4.5 их наяд төгрөгөөр хэмжигдэж байна. Иймд Монголбанкнаас зээлийн

тасалдал үүсэхээс сэргийлэн тодорхой төлөвлөгөөг Засгийн газар болон бусад талуудтай хамтран эрэлхийлэн ажиллаж байна.

ҮҮН ДЭЭР НЭМЭЭД АСУУХАД УЛАМЖЛАЛТ БУС АРГА ХЭРЭГСЛИЙН ОРОН ЗАЙ ДАРААГИЙН АСУУДЛУУДАД ХЭР БАЙНА ВЭ?

Аливаа бодлогын шийдвэр гаргаж, хэрэгжүүлэхдээ хамгийн гол нь улс орны эдийн засагт богино болон урт хугацаанд ямар үр дагавар авчрах вэ гэдэг анхаарвал зохино. Элсэн дээр ус асгаж байгаа мэт үр дүнгүй явах эсвэл богино хугацааны үр дүнд хэт төвлөрч, урт хугацаандаа асуудлууд үүсгээд байж болохгүй. Өнгөрсөн хугацаанд гарсан зарим шийдвэртэй холбоотойгоор ханшийн савлагаа зэрэг сөрөг үр дагавар гарсныг бүгд мэднэ. Тэгэхээр бид ийм бодлогын арга хэрэгслээс аль болох зайлсхийнэ.

Нөгөө талдаа бид олон улсын байгууллагуудтай байнга санал солилцож байгаа. Мөн зарим ижил, төстэй орнуудын уламжлалт болон уламжлалт бус бодлогын арга хэрэгслүүдийг ашиглаж байгаа туршлага, хэрэгжилт дээр судалгаа хийж байна. Үүн дээр тодруулж хэлэхэд судалгаа хийж байна гээд зогсохгүй аль болох зохих шийдвэрийг гаргаж байгаа. Мэдээж зохицуулагч байгууллагын хувьд аливаа

эрсдэлийг тохиолдохоос өмнө стресс тест хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байгаа гэдгийг хэлэх нь зүйтэй.

Ярилцсанд баярлалаа.

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААР

УИХ-ын намрын чуулганаар Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталсан. Ингэснээр банкууд хувьцаат компани болж, банкны эздийн хувьцааны төвлөрөл 20 хувиас хэтрэхгүй байх хуулийн зохицуулалттай болов.



Сангийн сайд

Б.ЖАВХЛАН

Банкны систем жил ирэх тусам маш их өргөжиж, тэр хэрээр эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нь нэмэгдэж байна. Банкны систем ард иргэдийн мөнгөн хадгаламжийг их хэмжээгээр татан төвлөрүүлсэн. Тэр хэмжээгээр ард иргэд маань банкинд итгэж байна гэсэн үг. Тэгэхээр энэ нөхцөлд банкууд маань улам хариуцлагатай байх ёстой. Эрсдэл даах чадвартай байж, эрсдэлийг бууруулж, засаглалаа сайжруулах ёстой. Яг энэ зорилгоор банкны хуулийн өөрчлөлт орсон. Хамгийн эхэнд банк ард иргэдийн мөнгөн хадгаламжийг хэдий чинээгээр авна, төдий хэмжээгээр олон нийтийн хяналтанд байх ёстой. Тухайлбал, жижиг банкууд хувьцаат компани болно. Ингэхдээ нээлттэй юу, хаалттай юу гэдгээ өөрсдөө мэднэ. Системийн ач холбогдолтой банкуудын хувьд иргэд, аж ахуйн нэгжүүдийн харилцах, хадгаламжийг ихээр татаж байгаа учраас илүү нээлттэй байх ёстой гэдэг зарчмаараа хувьцаат компани, тэр дундаа нээлттэй байх ёстой гэсэн үг. Тэгэхээр банкууд хуульд заасан хугацаанд энэ шаардлагыг биелүүлэх үүрэгтэй. Хоёрдугаарт, нэг хувьцаа эзэмшигчийн дээд хязгаарыг зааж өгсөн. Одоогоор манайд 12 банк үйл ажиллагаа явуулж байна. 12 банк маань үндсэндээ 12 томоохон хувьцаа эзэмшигчтэй л ажиллаж байна. Тэгэхээр банкууд одоо нийгмийн хариуцлагаа илүү үүрэх ёстой. Цаг хугацаа нь ч боллоо. Бизнес "Бүх өндгөө нэг хайрцганд хийж болохгүй" гэдэг зарчим бий. Энэ агуулгаар нь харвал ард иргэдийн мөнгөн хадгаламж, харилцахын өмнөөс төр шийдвэр гаргаж байгаа учраас бүгдийг нь нэг хайрцганд хийж болохгүй. Тэгэхээр нэг банк нэг эзэмшигчтэй байж болохгүй. Банкны эзэмшигч бүр дээд тал нь 20 хувь хүртэлх хувьцаа эзэмшинэ. Энэ бол реформын шинжтэй маш том өөрчлөлт болсон.



Монголын Банкны Холбооны
гүйцэтгэх захирал

Л.АМАР

Банкны тухай хуулиар нэг хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн дээд хязгаарыг 20 хувь гэж тогтоосон. Энэ шаардлагыг банкууд 2023 оны эцэс гэхэд биелүүлсэн байх ёстой. Яг одоогийн нөхцөлд бол 2-3 банк л хөрөнгийн зах зээл дээр гарахад нийт хөрөнгийн зах зээлийнхээ үнэлгээнээс илүү гарахаар байгаа. Уг нь анх хуулийн төслийг өргөн барихдаа 2025 оны эцсээр хэрэгжүүлэхээр байсан юм билээ. Тэгэхээр хууль батлагдсан хэдий ч цаг хугацааны хувьд хэрэгжихгүй байх магадлал нэмэгдэх вий гэх болгоомжлол байна. Ковидын нөхцөл байдлаас хамаараад эдийн засгийн хямрал хэдий хугацаанд үргэлжлэх вэ? 2021 он бас хүнд жил болох нь ойлгомжтой л байна. Дэлхийн улс орнууд хүн амаа вакцинд хамруулаад, эдийн засаг хэвийн үеийнх шигээ ажиллаж эхлэх хүртэл багагүй хугацаа шаардлагатай. Ийм нөхцөлд гадны хөрөнгө оруулалтыг татах, дотоодын хөрөнгийн зах зээл дээр гарах таатай орчин бүрдэх үү гэдэг дээр эргэлзээ бий. Энэ тал дээр олон улсын сайн туршлагыг харвал Төв банкнаас зөвшөөрөл өгдөг юм билээ. Өөрөөр хэлбэл, дангаараа болон хамаарал бүхий этгээдүүдийн хамтаар эзэмших хувьцааны дээд хязгаар 20 хувь

байлаа гэхэд, тэрнээс дээш 40 хувь хүртэл эзэмшиж болно. Гагцхүү 20-оос дээш гарах хувь болгон дээр нь Төв банкнаас хяналт тавьж, зөвшөөрөл олгох байдлаар явна гэсэн үг. Иймэрхүү байдлаар харьцангуй уян хатан шийдлийг оруулж ирвэл хуулийн хэрэгжилт талаасаа илүү ач холбогдолтой болов уу. Мэдээж банк хувьцаат компани болсноор ТУЗ, гүйцэтгэх удирдлага нь нэг хүнээс хамааралтай байх эрсдэл буурна. Гэхдээ зөвхөн хөрөнгийн бирж дээр гарснаараа бүх зүйл шийдэгдэнэ гэвэл бас учир дутагдалтай. Энэ нөхцөлд олон улсын хамгийн сайн жишгийн дагуу зөв хийж байж л энэ реформ амжилттай болно. Банкны салбарын хувьд энэ реформыг олон улсын сайн засаглалын жишээ гэж харж байгаа учраас дэмжиж байгаа. Харин яаж хэрэгжүүлбэл, банкны салбар болон Монголын эдийн засагт хамгийн сайн үр нөлөөтэй байх вэ гэдэг талаас нь харж байна.



Монголын хөрөнгийн биржийн
гүйцэтгэх захирал

Х.АЛТАЙ

Юуны өмнө Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа нь цагаа олсон зөв алхам гэж бодож байна. Банк бол өвөрмөц бизнес. Өөр дээрээ хадгаламж, харилцахыг төвлөрүүлдэг. Тэгэхээр харилцагчаас хамаардаг, харилцагчидтайгаа уялдаатай явдаг бизнес. Хувьцаат компани болсноор хадгаламж эзэмшиж байгаа харилцагчид нь банкныхаа хувьцаа эзэмшигч болох боломжтой. Ингэснээр банкны засаглал сайжрахад чухал үр нөлөө үзүүлэх болов уу. Нөгөөтэйгүүр Банкны тухай хуулиас гадна бас нэг чухал хууль хэлэлцэгдэж байгаа. Энэ нь Хувийн тэтгэврийн сангийн тухай хууль. Өөрөөр хэлбэл, хуулийг баталснаар хувийн тэтгэврийн сангууд үүсч, бий болно. Энэ сангуудад хуримтлагдах иргэд бидний ирээдүйд авах хуримтлал нь хөрөнгийн захаар дамжаад банкуудын хувьчлал гэх зэрэгт зарцуулагдах боломжтой.

Ингэснээр иргэдийн ирээдүйд авах хуримтлал нь банкуудын үйл ажиллагааны өгөөжөөр арвижна. Өнөөдрийн байдлаар хөрөнгийн бирж дээр нийт бүртгэлтэй байгаа компаниудын зах зээлийн үнэлгээ 3 их наяд гаруй төгрөг байна. Энэ нь манай ДНБ-ий 10 орчим хувьтай тэнцэж байна. Хөрөнгийн бирж дээр сайн бүтээгдэхүүн гарвал энэ багтаамж нэмэгдэнэ гэсэн үг. Зөвхөн банкны харилцах, хадгаламж бус гадны хөрөнгө оруулалтыг татах, дуудах их том суваг болно. Тэгэхээр багтаамжийн хувьд бүтээгдэхүүн нь өөрөө сайн бүтээгдэхүүн байвал багтаамж тэлэх бүрэн боломжтой. Нөгөөтэйгүүр дээр дурдсанчлан тэтгэврийн шинэчлэлийг үүнтэй уялдуулж өгвөл багтаамжийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй. Хөрөнгийн зах зээл хөгжих нь бүх талуудад хэрэгтэй, ашигтай. Тэгэхээр банкны хуулийн шинэчлэл болон тэтгэврийн шинэчлэлийн асуудал нь Монголын эдийн засгийг цоо шинэ шатанд хүргэх тулгуур хууль болно.



Банкны тухай хуульд орсон онцлох өөрчлөлтүүд



Банкийг нээлттэй болгох

Системийн нөлөө бүхий банкууд хуулийн зохицуулалтаар 2022 оны зургаадугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болж, санхүүгийн зах зээлд IPO гаргана. Харин бусад банкуудад нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани байх сонголт хийх эрхийг нээлттэй үлдээнэ.



Хувьцаа эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах

Нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийнхээ хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй хэмжээний хувийг эзэмшихээр тусгав.



Банк татан буугдсан үед төлбөр барагдуулах дарааллыг ойлгомжтой болгох

Иргэд тэргүүн ээлжинд хадгаламж болон харилцах дансанд байгаа өөрийн мөнгөн хөрөнгийг хуулийн этгээдийн өмнө буюу тэдгээрээс тэргүүн ээлжинд авах зохицуулалтыг тусгаж өгсөн. Дараа нь хуулийн этгээд, түүний дараа Засгийн газар, УИХ-ын харьяа байгууллагууд гэх зэргээр төрийн байгууллагууд байхаар төлбөр барагдуулах дарааллыг нарийвчлан тусгалаа.



Банкны систем дэх нөлөө бүхий банкны тодорхойлолтыг нарийвчлан боловсронгуй болгох

Системийн таваас дээш хувийг эзэлвэл системийн нөлөө бүхий банк гэж үздэг байсныг банкны хөрөнгө, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал, мөн харилцагчдын тоо бусад хүчин зүйлсийг баримтлахаар болов.



МОНГОЛБАНКНЫ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛААС

Монголбанкны ээлжит хэвлэлийн бага хурал 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр болж, цаг үеийн асуудлаар сэтгүүлчдийн асуултад хариуллаа.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл батлагдлаа. Хууль батлагдсанаар банкны салбарт ямар онцлог өөрчлөлт орох вэ. Хуулийн онцлох заалтуудыг хэрэгжүүлэхгүй бол ямар арга хэмжээ авах вэ?

БАНКНЫ БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТ, БОДЛОГЫН ГАЗАР (ББӨБГ)-ЫН ЗАХИРАЛ Н.АРИУНБАТ:

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-аар 2021 оны нэгдүгээр сарын 28-ны өдөр хэлэлцэж, баталсан. Үүгээр орж байгаа өөрчлөлтийн гол агуулгыг 4 хэсэгт авч үзэж болно. Нэгдүгээрт, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 12 банкиг нээлттэй болон хаалттай ХК болгох үйл ажиллагаа юм. Үүний 5 банк нь системийн нөлөө бүхий банк бөгөөд хуулийн зохицуулалтаар 2022 оны 6 дугаар сарын 30 өдрийн дотор нээлттэй хувьцаат компани болж, санхүүгийн зах зээл дээр IPO гаргасан байх ёстой. Бусад банкны хувьд нээлттэй болон хаалттай ХК

хэлбэрээр үйл ажиллагаа явуулж болно. Хоёрдугаарт, хувь нийлүүлэгчдийн хувьцааны төвлөрлийг 20 хувиар хязгаарлаж байна. Энэ хязгаарлалт нь банкны шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа ажил бөгөөд нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийн хамтаар тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20-оос хэтрэхгүй хувийн хувьцаа эзэмших зохицуулалттай. Энэ зохицуулалтыг банкууд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангасан байх ёстой. Ингэснээр Монголд үйл ажиллагаа явуулж буй хувь эзэмшлийн төвлөрөл буурна. Гуравдугаарт, банк татан буугдсан үед төлбөр барагдуулах дарааллыг ойлгомжтой болгох буюу хуримтлалтай иргэн, өрхийн хууль ёсны эрхийг хамгаалах байдлаар хуулийн төсөлд тусгаж өгсөн. Дөрөвдүгээрт, банкны систем дэх нөлөө бүхий банкуудын тодорхойлолтыг нарийвчлан тусгаж өглөө. Системд нөлөө бүхий банкны тодорхойлолтыг Банкны салбарын тогтвортой байдлын тухай хуульд зааж өгсөн байдаг. Үүгээр нийт системийн 5-аас дээш

хувийг эзэлж байгаа банкны системд нөлөө бүхий банк гэж үздэг. Тэгвэл энэ удаагийн хуулиар банкны системд эзэлж байгаа хувь хэмжээнээс гадна гүйлгээний дүн, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоон дахь хамаарал, харилцагчдын тоо гэх зэрэг олон хүчин зүйлийг авч үзэхээр тусгасан. Банкууд нээлттэй компани болсноор Монгол Улсын хөрөнгийн зах зээлд нэлээд ахиц дэвшил гарна гэж үзэж байгаа. Өнөөгийн байдлаар банкны систем нийт санхүүгийн зах зээлийн 90 гаруй хувийг дангаараа бүрдүүлж байна. Банкууд нээлттэй хувьцаат компани болсноор хөрөнгийн зах зээлийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулна.

Хуулийн төслийг хэлэлцүүлэх, батлах явцад банкуудын байр суурийг хэр тусгасан бэ. Хэрэгжих хугацааны тухайд ялангуяа банкны эзэд ямар байр суурьтай байгаа бол?

ББӨБГ-ЫН ЗАХИРАЛ Н.АРИУНБАТ:

Энэ хуульд банкуудын саналыг авч, тусгаж өгсөн. Ялангуяа дэд ажлын хэсэгт Банкны холбооны төлөөлөл оролцож, ажилласан. Тэгэхээр банкууд банкны холбоогоороо дамжуулан хуулийн төсөлд эхний хэлэлцүүлгээс эцсийн хэлэлцүүлэг хүртэл оролцоотой байж, саналаа өгч байсан.

Бодлогын хүүг бууруулсан нь бодит эдийн засагт нөлөөгөө үзүүлж эхэлсэн үү?

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ (МБГ)-ЫН Б.БАЯРДАВАА:

2020 оны 12 дугаар сард хуралдсан Мөнгөний бодлогын хорооны хурлаар бодлогын хүүг 2 нэгж хувиар бууруулсан. Үүний гол нөлөө нь эдийн засгийн сэргэлтийн хугацааг 2-3 улирлаар наашлуулж өгч байгаа. Дээрээс нь Монголбанкаас арилжааны банкууд руу гарах санхүүжилтийн хүү 8 хувиас 6 хувь болж буурч байгаа. Энэхүү 6 хувийн хүүгээр банкуудад олгосон санхүүжилтийн дүн нь дөрөвдүгээр улиралд 230 тэрбум төгрөг байсан. Энэхүү санхүүжилтийн зарцуулалтыг 1 дүгээр сарын 25-ны байдлаар нэгтэж үзвэл 192 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэх болон шинээр олгох хэлцлүүд хийгдэж байна. Үүнээс 82.9 тэрбум төгрөгийн зээлд гэрээ байгуулагдаж, эцсийн зээлдүүлэгчид зээл олгогдсон төлөвтэй байна. Монголбанкны зүгээс нийт зээлийн өсөлтийг 12-15 орчим хувьтай байх болов уу гэсэн төсөөллийг 12 дугаар

сарын мөнгөний бодлогын хорооны хурлын үеэр хийж байсан. Цаашид гуравдугаар сарын мөнгөний бодлогын хорооны хурлын үеэр энэхүү төсөөллүүд шинэчлэгдэнэ.

Цар тахалтай үед иргэд, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн зээлийн хэмжээ нэмэгдсэн үү?

МБГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

Дээр дурдсанчлан 230 тэрбум төгрөгийн санхүүжилтээс гадна 2021 оны нэгдүгээр улиралд 250 тэрбум төгрөгийн санхүүжилтийг жижиг, дунд бизнес болон уул уурхайн бус экспортын салбарт олгохоор шийдвэрлэсэн. Энэ санхүүжилт нь ЖДҮ-ийн хувьд 300 хүртэлх сая төгрөгийн шинээр зээл олгох эсвэл тэр хэмжээний зээлийг дахин санхүүжүүлэх нөхцөлтэй. Мөн уул уурхайн бус экспортын салбарын хувьд нэг зээлдэгчид очих зээлийн дээд хэмжээ 1 тэрбум төгрөг байгаа. Монголбанкаас хэдийгээр 6 хувийн хүүтэй санхүүжилт гарч байгаа боловч банкаар дамжаад эцсийн зээлдэгчид очиж байгаа хүү нь 10.5 хувь буюу зах зээлийн хүүнээс харьцангуй бага байна. Энэ нь шинэ зээл олголтыг дэмжихээс гадна одоо хүндрэлд орсон байгаа зээлийг дахин санхүүжүүлэх зорилготой. Энэ арга хэмжээ нь зээл олгох мотивацийг дэмжиж, хөшүүрэгдэх боломжтой. Хугацааны хувьд 2 жил хүртэлх хугацаатай. Энэ нь Монголбанкны уламжлалт репо санхүүжилтийн нөхцөлийг өөрчлөх замаар хийгдэж байгаа бөгөөд хугацааны хувьд хоёр жил. Репо хэлцэл хийх актив нь банкуудын хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасыг барьцаалах замаар энэ хэлцэл хийгдэж байгаа.

2021 онд төгрөгийн ханш сулрах, чангарах эсэх дээр ямар хүлээлт байна вэ, гол нөлөөлөх хүчин зүйл юу байна вэ?

МБГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

Бидний одоо хүлээж буйгаар 2020 оны төлбөрийн тэнцэл 700 орчим сая ам.долларын ашигтай гарах хүлээлт байна. Мөн 2020 оны гадаад валютын албан нөөц 4.5 тэрбум ам.долларт хүрсэн. Энэ нь ханшийн төлөв байдлыг илтгэх тоонууд болов уу. Нөгөө талаас 2021 оны эдийн засгийн төлөв байдал ямар байх вэ гэдэг нь ханшид тодорхой хэмжээнд нөлөөлнө. Ялангуяа гадаад эдийн засгийн орчин ямар байх, гадаад эдийн засгийн орчны тусгал болсон эрдсийн бүтээгдэхүүний үнэ ямар байх вэ гэдэг нь чухал нөлөөтэй. Зэсийн үнэ харьцангуй гүйцэтгэл сайтай байгаа. 2021 гарснаас

хойш зэсийн үнэ 7900-8000 орчимд тогтвортой байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27 хувиар өссөн үзүүлэлт. Төмрийн хүдрийн үнэ 160 орчим доллар. Энэ нь жилийн өмнөхтэй харьцуулахад 80 гаруй хувийн өсөлттэй байна. Алтны үнэ 1800-1850 орчим ам.доллар байгаа нь өмнөх онтой харьцуулахад 16 орчим хувиар өссөн байна. Газрын тосны үнэ эргээд сэргэж, Брэнт маркийн газрын тосны үнэ 55-56 орчим ам.доллартай тэнцэж байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 16 орчим хувиар буурсан үзүүлэлт. Монгол Улс цэвэр дүнгээрээ нефтийн бүтээгдэхүүнийг импортлогч улс. Монгол улс 1.2-1.3 тэрбум ам.долларын нефтийн бүтээгдэхүүнийг 2019 онд буюу нефтийн бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр байх үед ОХУ-аас импортолж авсан. Нефтийн үнийн бууралттай холбоотойгоор 2020 онд энэ дүн 30 орчим хувиар буурсан. Энэ нь худалдааны нөхцөлийг сайжруулж, ялангуяа уул уурхайн салбарын компаниудын үйл ажиллагааны зардлыг бууруулах эерэг нөлөө үзүүлсэн. Монгол Улсын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний үнэ буурах хандлагатай байгаа ч олон улсын харилцааны хүчин зүйлсүүд нөлөөлөл үзүүлж байна. Нөгөө талаас манай гол экспортлогч орон болох БНХАУ-ын эдийн засаг эргээд сэргэж байгаа нь ган болон төмрийн хүдэр, нүүрсний үнэд эерэн нөлөө үзүүлж байгаа. Хамгийн сүүлийн мэдээгээр Хятадын эдийн засаг 4 дүгээр улиралдаа 6 хувь давж өссөн байна. Жилийн дүнгээрээ 2 хувийн өсөлттэй байна. ОУВС болон дэлхийн банкны зүгээс 2021 оны сүүлийн хагаст дэлхийн эдийн засаг сэргэнэ гэсэн хүлээлттэй байна. Гэхдээ улс орнуудын хувьд эдийн засгийн сэргэлтийн нөхцөл байдал харилцан адилгүй байна гэдгийг онцолж байгаа. Яагаад гэвэл Ковид-19 цар тахлын идэвхжил, хоёр дахь давлагаа нь нэлээд хүчтэй байна. Үүнтэй холбоотойгоор АНУ болон Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулж байгаа ч дэлхийн эдийн засгийн төлөв эерэг байна. Тэр дундаа Хятадын эдийн засгийн өсөлтийг 7.9 нэгж хувьтай байхаар төсөөлсөн байна билээ. Энэ нь өмнөх төсөөлөлтэй харьцуулахад нэг пунктээр өссөн байгаа. Тэгэхээр экспортын гадаад худалдааны тээвэрлэлтэд ямар нэгэн саад тогтор учрахгүй байх тохиолдолд үнэ, эрэлт талаасаа 2021 онд ихээхэн эерэг төлөв байдал хүлээгдэж байна. Энэ нь төлбөрийн тэнцэлд эерэг нөлөө үзүүлнэ. Төлбөрийн тэнцэл нь валютын орох гарах урсгал учраас ханшийн төлөв байдлыг ч бас илэрхийлнэ.

Монголбанк бодлогын хүүгээ бууруулсан ч Төв банкны үнэт цаасны хэмжээ нэмэгдсээр байна. Зээл эдийн засаг руу идэвхтэй гарахгүй байгаа гол шалтгааныг Төв банк хэрхэн харж, дүгнэж байгаа вэ?

МБГ-ЫН ЗАХИРАЛ Б.БАЯРДАВАА:

Арилжааны банкууд дээр 7 гаруй их наяд төгрөг байгаа нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахтай холбоотой нөөц гэж ойлгох хэрэгтэй. Нөгөө талдаа зээлийн өсөлт нь эдийн засгийн идэвхжилтэй уялдаж байх ёстой. Өөрөөр хэлбэл, бизнесийн идэвхжил сэргэсний дараа зээлийн бодит эрэлтүүд бий болно. Өнөөдрийн хувьд өмнө нь авсан зээлүүдээ яаж төлөх вэ гэдэг асуудал бизнес эрхлэгчдийн хувьд хүнд байгаа. Энэ хүндрэлтэй асуудлыг шийдэхийн тулд Монголбанкнаас арилжааны банкууд руу өгсөн чиглэл нь хэрэглээний болон бизнесийн зээлийн хувьд зээлдэгчийн нөхцөл байдалтай уялдуулж, зээлийн эргэн төлөлтийг дахин шинэчлэх чиглэлийг өгсөн. Үүний хүрээнд хэрэгжилтийг Монголбанк 14 хоног тутамд авч нэгтгэж байгаа. Үүний дагуу зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах ажил хэвийн үргэлжилж байгаа.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ


2021 оны 1 дүгээр сар

1. Мөнгөний үзүүлэлт

Зураг 1.1. Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (эх үүсвэр талаас)




Зураг 1.2 Мөнгөний нийлүүлэлтийн жилийн өсөлтийн бүтэц (байршуулалт талаас)




- Мөнгөний нийлүүлэлт (M2 мөнгө) өмнөх оны мөн үеэс **16.3** хувиар өсч **24.2** их наяд төгрөгт хүрлээ. M2 мөнгөний жилийн өсөлтийн **10.9** нэгж хувийг төгрөгийн хадгаламж, **5.6** нэгж хувийг гадаад валютын хадгаламж, **0.7** нэгж хувийг төгрөгийн харилцах, **0.7** нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө, **-1.6** нэгж хувийг гадаад валютын харилцах тус тус бүрдүүлж байна.
- M2 мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр актив (ДЦА)-ын дүн **18.7** их наяд төгрөг, гадаад цэвэр актив (ГЦА)-ын дүн **5.6** их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна.

2. Зээл

Зураг 2.1. Зээлийн үлдэгдлийн жилийн өсөлт, сектороор




Зураг 2.2. Зээл, зээлийн чанар




- Нийт зээл **17.0** их наяд төгрөг (төгрөгийн зээл **15.4** их наяд, гадаад валютын зээл **1.6** их наяд төгрөг)
- Зээлийн үлдэгдэл өмнөх сараас **1.3%**-иар
- Хэвийн зээл өмнөх сараас **1.2%**-иар
- Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас **7.6%**-иар өсч,
- Чанаргүй зээл өмнөх сараас **0.2%**-иар буурсан байна.

2. Зээл /үргэлжлэл/

Зураг 2.3. Нийт зээл, гадаад валютын зээлийн эзлэх хувь




Зураг 2.4. Зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбарын ангиллаар



- Банкуудын зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс **5.0%**-иар буурч **17.0** их наяд төгрөгт,
- Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл **7.9%**-иар буурч **8.5** их наяд,
- Хувийн байгууллагуудынх **6.6%**-иар буурч **7.9** их наяд төгрөгт тус тус хүрчээ.
- Нийт зээлийн **9.3%**-ийг, иргэдийн зээлийн **0.8%**-ийг, хувийн байгууллагын зээлийн **18.2%**-ийг гадаад валютын зээл бүрдүүлж байна.

3. Ипотекийн зээл

Зураг 3.1. Ипотекийн зээлийн үлдэгдэл санхүүжилтийн эх үүсвэрээр



Зураг 3.2. Ипотекийн зээлийн чанарын үзүүлэлт




- Ипотекийн нийт зээлийн үлдэгдлийн **74.0** хувь нь хөтөлбөрийн зээл, **22.1** хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, **3.9** хувь нь бусад эх үүсвэрээр олгосон зээл эзэлж байна.
- Орон нутгийн ипотекийн зээл*-ийн **75.4** хувь нь хөтөлбөрийн зээл, **22.3** хувь нь банкуудын өөрийн эх үүсвэрээр, **2.3** хувь нь бусад эх үүсвэрээр олгогджээ.

- Нийт ипотекийн зээлийн үлдэгдлийн **94.1** хувь нь хэвийн, **2.9** хувь нь хугацаа хэтэрсэн, **2.9** хувь нь чанаргүй зээл байна.
- Чанаргүй ангилалд шилжсэн ипотекийн зээлийн **54.0** хувийг банкуудын өөрийн эх үүсвэрээр олгосон зээл, **45.2** хувийг хөтөлбөрийн зээл, **0.8** хувийг бусад эх үүсвэрийн зээл тус тус эзэлж байна.


*Уг зээл нь орон нутгийн банкны салбараас олгосон бус худалдан авсан орон сууцны байршлаар тооцсон.

4. Хүү

Зураг 4.1. Нийт шинээр татсан хадгаламжийн хүү




Зураг 4.2. Нийт шинээр олгосон зээлийн хүү



- 2020 оны 12 дүгээр сард нийт шинээр татсан төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү (ЖДХ) **8.4** хувь, гадаад валютын хадгаламжийн ЖДХ **3.7** хувь байна. Төгрөгийн хадгаламжийн ЖДХ өмнөх оны мөн үеэс **2.2** нэгж хувиар буурчээ.
- Тайлант сард нийт шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ **14.8** хувь, гадаад валютын зээлийн ЖДХ **9.8** хувь болж, шинээр олгосон төгрөгийн зээлийн ЖДХ өмнөх оны мөн үеэс **2.1** нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна

*Хөтөлбөрийн зээл, Хөгжлийн банкны санхүүжилтийн зээлийн дүнгүүдийг оруулаагүй болно.

5.1. Төлбөрийн тэнцлийн статистик, 2020 оны эхний 12 сар /урьдчилсан/



МОНГОЛБАНК

Зорилт 1

Банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, банкны үйл ажиллагааны зохистой засаглалыг сайжруулан ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай банкны тогтолцоог бий болгох

Зорилт 2

Банкны хяналт шалгалт, зохицуулалтын арга хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн эрүүл найдвартай банкны тогтолцоог бий болгох

Зорилт 3

Олон улсын мэргэжлийн байгууллагуудтай хийх хамтын ажиллагааг үргэлжлүүлж, дараагийн санхүүжилтийн хөтөлбөрт бэлтгэх

Зорилт 4

Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах, ФАТФ-ын саарал жагсаалтаас гарах, дараагийн харилцан үнэлгээнд бэлтгэх

Зорилт 5

Банкны үйл ажиллагааны чиглэл, бизнесийн загвар болон бусад онцлог хүчин зүйлд тулгуурлан банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, тавигдах шаардлагыг төрөлжүүлэн харилцагчид хүртээмжтэй, цахимжсан банкны тогтолцоог бий болгох

Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчдад хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийн зорилтууд

**Ё.МӨНХБАТ**

Монголбанкны Банкны
бүтцийн өөрчлөлт, бодлогын
газрын Бүтцийн өөрчлөлтийн
хэлтсийн захирал

НИРГЭСЭН ХОЙНО НЬ ХАШХИРАХ БУС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛНЭ

Эрүүл тогтолцооны үндэс

Банк бол бизнес, гэхдээ тун онцлогтой, эмзэг бизнес. Итгэлцэл дээр тогтдог учраас тэр. Хэрэв банк хүндрэлд орвол зөвхөн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид бус ард, олон нийтийн хөрөнгө эрсдэлд орохоос гадна эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх учир банкны салбар заавал “эрүүл” байх ёстой. Эрүүл байх үндэс нь “өвчнөөс” урьдчилан сэргийлэх. Энэ зарчмын дагуу эрсдэлд суурилсан банкны хяналт шалгалт, зохицуулалтын олон улсын аргачлалыг Монгол Улсын онцлогт нийцүүлэн үе шаттайгаар нэвтрүүлэх ажлыг Монголбанк хэрэгжүүлж байна.

Төв банкнаас арилжааны банкуудад тавьж буй хяналт шалгалт нь олон нийтийн эрх ашгийг хамгаалахын зэрэгцээ эдийн засгийн үр өгөөжтэй, эрсдэл багатай хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэдэг. Харин эрсдэл даах чадварыг оновчтой тогтоож, санхүүгийн салбарын оролцогчдыг үнэн зөв мэдээллээр хангахын тулд олон улсын банкны хяналт шалгалтын Базелийн хорооны Базел I, II, III цуврал стандартыг Төв банк дотоодын банкны системийн онцлогт нийцүүлэн хэсэгчлэн нэвтрүүлж хэрэгжүүлж буй. Эдгээр стандарт нь санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, зохистой засаглал, төлбөрийн чадварын үзүүлэлт болон үр нөлөөтэй хяналт шалгалтын зарчмын шалгуурыг тогтоож өгдгөөрөө ач холбогдолтой юм.

Туршлагаар шалгарсан стандарт

1974 онд валютын зах зээлийн гол

тоглогчдын нэг Германы Герштат банк долларын ханшийг буруу тооцсоны улмаас өөрийн хөрөнгөөс даруй 10 дахин их хэмжээний өрөнд орж дампуурчээ. Тухайн өдөр хэд хэдэн банк эл банкаар дамжуулан АНУ-руу гүйлгээ хийсэн боловч цагийн зөрүүний улмаас эдгээр шилжүүлгийг хийхээс өмнө татан буулгасан байв. Гинжин урвалын зарчмаар тэдгээр банк мөнгөн хөрөнгийн дутагдалд орж, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон юм. Энэ туршлагаас сургамж авсан “Их 10”-ын төв банкны удирдлагууд 1974 оны сүүлчээр Олон улсын төлбөр тооцооны банкны дэргэд Базелийн хороог анх байгуулжээ. Энэ үеэс олон улсын банкны хяналт шалгалтын аргачлалын суурь тавигдаж эхэлсэн байна.

1988 онд тус хорооны баталсан Базел I стандартаар банкуудад тавих өөрийн хөрөнгийн зохистой харьцааны тухай ойлголт анх бий болсон. Энэ баримт бичиг батлагдсанаар банкуудын балансын болон балансын гадуурх бүртгэлд өөрийн хөрөнгө хүрэлцээтэй байгаа эсхийг тодорхойлох замаар зээлийн эрсдэлийг анхаарч эхэлсэн байна. Гэтэл 1990-ээд оны үед хэд хэдэн улсад эдийн засгийн болон санхүүгийн хямрал тохиосон бөгөөд 1997 оны Азийн санхүүгийн хямрал олон улсын хөрөнгө оруулагчдыг нэг их наяд орчим ам.долларын алдагдалд орууллаа. Энэ нь санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын механизм сул байгааг илтгэсэн дохио байв. Улмаар шинэ зууны эхээр Базелийн

хороо банкуудын өөрийн хөрөнгөд тавих шаардлагыг өөрчлөх санал гаргасан нь Базел II стандартын суурийг тавьжээ.

2006 онд батлагдсан Базел II стандарт нь өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагаас гадна хяналт шалгалт болон олон нийтэд нээлттэй байх шаардлагуудыг нэмж тусгасан гурван бүлэгтэй. Уг стандартын Бүлэг 1-т өөрийн хөрөнгийн зохистой харьцааг тусгасан бол Бүлэг 2 нь банкуудын эрсдэлд суурилсан, ирээдүйд чиглэсэн дотоод хяналт шалгалтын шаардлагыг нарийн зааж өгснөөрөө онцлогтой. Харин Бүлэг 3 нь банк өөрийн хөрөнгийн бүтэц, эрсдэлтэй активын талаар олон нийтэд мэдээлэх шаардлага тавьж, зах зээлийн сахилга батыг бэхжүүлэхэд чиглэдэг. Ингэснээр банкинд тавих олон нийтийн хяналт идэвхжиж, тэр чинээгээр банкууд хариуцлагатай үйл ажиллагаа явуулах нөхцөл бүрдэх юм.

Энэхүү шаардлага батлагдаад удаагүй байтал 2008 оны олон улсын санхүүгийн хямрал нүүрлэсэн нь Базел II стандартыг чангатгах хэрэгтэйг анхааруулав. Банкны салбар хямарсан нь зээлээр бүрдүүлсэн хөрөнгө хэт их бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар хангалтгүй байсантай холбоотой. Банкуудын засаглал, эрсдэлийн удирдлага сул, урамшууллын бүтэц зохисгүй байсан нь “нэмэр” болж улмаар зээл болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлээ буруу тооцож, хэт их зээл олгосон нь хямралд хүргэжээ. Энэ бүх эрсдэлийг нарийн тооцож, өмнөх

стандартын шаардлага, хамрах хүрээг өргөжүүлэн чангатгасан Базел III стандартыг 2010 онд батлан мөрдүүлж эхэлсэн байна.

Базел стандарт Монголд

Монгол Улс 1996 онд Базел I буюу өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагыг анх нэвтрүүлсэн. Зах зээлийн эдийн засагт шилжиж байсан тухайн үед зээлийн ангилал байтугай зээлийн тухай ойлголт муутай байсан монголчуудад сэтгэлгээний том өөрчлөлт хийх шаардлага тулгарав. Энэ үеэс хойш 2017 он хүртэл банкны хяналт шалгалтын аргачлалд зарчмын өөрчлөлт оролгүй явсаар ОУВС-ийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр хэрэгжсэнээр шинэтгэлийн эхлэл тавигджээ.



Арилжааны банкуудад 2017 онд хийсэн активын чанарын үнэлгээний үр дүнд нийт долоон банк 511 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгийн дутагдалтай гарсан. Банкууд өөрийн хөрөнгөө нэмэгдүүлсэн боловч зарим банкны бүрдүүлсэн эх үүсвэрийг Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих хуультай холбоотойгоор хүлээн зөвшөөрөх боломжгүйг Монголбанк мэдэгдэж байв. Активын чанарын үнэлгээгээр банкуудын зээл олгох процесс учир дутагдалтай буюу эрсдэлийн удирдлагын тогтолцоо сул байгааг тогтоожээ. Түүнчлэн, эргэн төлөх чадвар бус барьцаанд суурилсан зээл олгох тогтолцоотой боловч

барьцаа хөрөнгийн үнэлгээ нь олон улсын стандартад нийцээгүй зэрэг банкны салбарын олон сул тал ил болсон юм. Улмаар 2017 оноос Монголбанк Базел II стандартын Бүлэг 2-ыг нэвтрүүлэх чухал алхмыг хийсэн нь банкуудын системд нөлөөтэй байдлыг тооцож банк тус бүрт тохирсон хяналт шалгалтын аргачлалыг нэвтрүүлсэн явдал байв. Мөн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны шаардлагаас гадна банкуудад тодорхой хэмжээний нөөц хөрөнгөтэй байх, гурван жилийн төлөвлөгөө шаарддаг болсноос гадна эрсдэлээр жигнэсэн активын харьцааг илүү оновчтой болгож өгчээ. Харин ил тод байдлыг хангах үүднээс Монголбанкнаас банкны санхүүгийн тайлан болон бусад мэдээллийг нийтэд нээлттэй мэдээлэх загварыг боловсруулан мөрдүүлж байна.

Базел III стандартын хүрээнд Монголбанк Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны журамд өөрчлөлт оруулж мөрдүүлж эхэлсэн. Гэвч арилжааны банкууд зохистой харьцааны шалгуурыг хангаж чадалгүй явсаар дэлхий даяар Ковид-19 цар тахал дэгдэж, эдийн засгийн нөхцөл муудсанаар уг шаардлагыг хангах хугацаа хойшилсоор байна. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын аргачлалд шилжих зорилгоор Банкны тухай хууль болон бүхий л холбогдох журмуудад нэмэлт, өөрчлөлт оруулаад байна. Ингэснээр банкуудад авах албадлагын арга хэмжээ зөвхөн гаргасан зөрчилтэй холбоотой байсан бол эрсдэлийн түвшинтэй уялдаж ирээдүйд чиглэсэн шинж чанартай болох юм. Монголбанкнаас эрүүл, найдвартай банкны тогтолцоог бий болгох цогц арга хэмжээ авч байгаа ч хэрэгжилт сул байгаа нь шинэтгэлийн явцыг удаашруулж байна. Дэлхийн банкнаас Монгол Улсын Засгийн

газарт зориулан бэлтгэсэн бодлогын тэмдэглэлд "хууль эрх зүйн орчин нь Монголбанкны хараат бус байдлыг сулруулж, хяналт шалгалтын үр нөлөөг муутгаж" буйг онцолжээ. Уг тэмдэглэлд "Монгол Улсад хэрэгжиж буй бүх хууль, журам нь хууль тогтоомжийн үндсэн зарчимд нийцтэй байх шаардлагатай гэж үзээд Монголбанкнаас гаргаж буй бүх журам батлагдахын өмнө Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэх шаардлагатай байдаг нь бодит байдал дээр аливаа журмыг боловсруулах явцад хөндлөнгөөс оролцох боломжийг нээж өгч байна. Иймд журам боловсруулах явцад хөндлөнгөөс нөлөөлөх боломжийг хязгаарлах зорилгоор Монголбанкнаас гаргаж буй аливаа дүрэм, журмыг зөвхөн голлох хуулиудтай нийцтэй байдлыг нь харгалзан үзэж ХЗДХ-ийн яаманд бүртгүүлэх нь зүйтэй" гэж дурджээ.

Хяналт шалгалтын аргачлалын үндсэн зарчмыг ийнхүү өөрчлөхөд зөвхөн банк төдийгүй бүх талын оролцоо чухал үүрэгтэйг энд онцлох хэрэгтэй. Тухайлбал, хянан шалгагчид шинэ шалгуур, аргачлалын зарчмыг сайтар ухамсарлаж чанарын үнэлгээ зэрэг субъектив үнэлэмж хийхдээ анхааралтай хандах шаардлагатай бол банкууд үүрэг хариуцлагаа ухамсарлаж эрсдэлээ зөв тооцож тохирох арга хэмжээг авдаг байх ёстой.

Түүнчлэн, олон нийт ч нээлттэй мэдээлэлд тулгуурлан эрсдэлээ тооцож банкинд хөрөнгө оруулах шийдвэрээ гаргадаг байх нь эрсдэлд суурилсан, ирээдүйд чиглэсэн хяналт шалгалтын чухал бүрэлдэхүүн юм. Иймд банк, хянагч, харилцагч гээд санхүүгийн салбарын бүх оролцогч хариуцлагаа ухамсарлаж, хандлагаа өөрчилж байж хуучин тогтолцоог халж чадна.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

ТАМГАНЫ АЛТАН ЦООЖ
ХАЙРЦАГНЫ ЦООЖ:

Жин: 35 гр

Хэмжээ: 3x 3x 1.2 см

Түлхүүр: 5.5x 1.2см, жин: 4гр

Энэхүү алт шармал цоож нь 3 өргөс шүд бүхий бичж дүрсэлсэн алт шармал, төмөр түлүүртэй. Цоожны толинд дөрвө дэлбээт цэцэг бүхий навчин хээтэй.





Б.БАТБААТАР: МОНГОЛ УЛСАД КРИПТО ВАЛЮТЫГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БИЙ БОЛГОХООР АЖИЛЛАЖ БАЙНА

*Санхүүгийн Мэдээллийн албаны дарга
Б.Батбаатартай ярилцлаа.*

Виртуал хөрөнгийн зохицуулалтын бодит шаардлага юу байгаа вэ?

Сүүлийн жилүүдэд дэвшилтэд технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээнүүд зах зээлд олноор бий болж дэлхийн эдийн засагт томоохон өөрчлөлтүүдийг авчирсаар байна. Энэ нь виртуал хөрөнгө хэмээх ойлголт юм. Үүнд бүх төрлийн крипто валютууд, токен зэрэг нилээн хэдэн бүтээгдэхүүн үйлчилгээнүүд хамаарч байгаа. Виртуал хөрөнгийн үйлчилгээ нь хялбар, хямд, түргэн, шуурхай боловч виртуал хөрөнгийн технологид суурилан хууль бусаар олсон хөрөнгө, орлогоо нуун дарагдуулах, цаашлаад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах хандлага олон улсад байгааг Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-аас онцолсоор байна. Иймд дэлхийн улс орнууд болон олон улсын байгууллагууд энэхүү асуудлыг анхааралдаа авч, виртуал хөрөнгийн хууль эрх зүйн зохицуулалтын тогтолцоог хөгжүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байгааг бүхий л орнуудаас шаардаж байна.

ФАТФ-аас мөнгө угаах, терроризм болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх олон улсын стандарт болох техник хэрэгжилтийн 40 зөвлөмжийн хэрэгжилтийг улс орнуудаас шаарддаг. Үүнтэй холбоотойгоор Зөвлөмж 15-д 2019 онд шинэ технологийн талаарх өөрчлөлт оруулж, виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн

үйлчилгээ үзүүлэгчдэд тавигдах шалгууруудыг тогтоосон. Үүний дагуу ФАТФ-аас дэлхийн улс орнууд зөвлөмжийн шаардлагуудыг хэрхэн биелүүлж байгааг жил бүр үнэлдэг бөгөөд Монгол Улсыг виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлага тавигдсан. Иймээс Монгол Улсын хувьд олон улсын шаардлага болох ФАТФ-ын зөвлөмжийг хэрэгжүүлэх замаар мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоогоо улам бэхжүүлэх, виртуал хөрөнгийн үйлчилгээ эрхлэх хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх ёстой болоод байна.

Бид ФАТФ-ын саарал жагсаалтаас өнгөрсөн онд гарсан, дараагийн хийгдэх гол ажил виртуал хөрөнгийн зохицуулалтын орчинг бий болгох уу?

Монгол Улсын хувьд ФАТФ-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай улс орнуудын жагсаалт буюу саарал жагсаалтаас 2020 оны 10 дугаар сард (1 жилийн хугацаанд) гарсан. Мөн Европын холбооны мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй гуравдагч улс орнуудын (хар жагсаалт) жагсаалтаас 2021 оны 01 дүгээр сард гарсан.

ФАТФ-аас виртуал хөрөнгийг дижиталаар шилжүүлэх, арилжаалах боломжтой төлбөрийн эсхүл хөрөнгө оруулалтын зорилгоор ашиглагдах үнэ цэнийн дижитал илэрхийлэл гэж тодорхойлсон. Хамгийн анхны виртуал хөрөнгө болох биткоин одоогоос 10 гаруй жилийн өмнө

үүсч бий болсон бөгөөд энэ салбар блокчэйн технологид суурилан тасралтгүй хөгжин өөрчлөгдөж байна. Иймд ФАТФ-аас улс орнуудыг виртуал хөрөнгөтэй холбоотой мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээ үнэлж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах, мөн виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг бүртгэх эсвэл тусгай зөвшөөрөл олгох, эрсдэлд суурилсан хяналт шалгалтад хамруулж, холбогдох зөрчилд арга хэмжээ авах, улмаар харилцагчдаа таньж мэдэх ажиллагааг хэрэгжүүлхийг үүрэг болгосон. Тэгэхээр бид ФАТФ-ын шаардлагыг хангасан хуулийн төсөл боловсруулж яаралтай батлуулах шаардлагатай.

Бусад оронд виртуал хөрөнгийн орчинг яаж зохицуулж байгаа вэ? манай орны нөхцөл байдал ямар байгаа вэ?

Виртуал хөрөнгийн зах зээл технологийн дэвшилд тулгуурлан хурдацтай хөгжиж, шинэ төрлийн крипто валют болон койнууд зах зээлд нэвтэрсээр байгаа тул энэ салбарын ирээдүйн чиг хандлага, хөгжил маш хурдацтай өөрчлөгдсөөр байна. Иймээс дэлхийн улс орнууд ФАТФ-ын шаардлагын дагуу виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр ялгаатай арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Тухайлбал, хөгжиж байгаа эдийн засагтай улс орнуудын хувьд виртуал хөрөнгийг хэрэглэх тал дээр тодорхой хязгаарлалттай зохицуулалттай эсвэл үгүйсгэсэн байр суурьтай байгаа. Барууны зарим улс орнууд болон Ази тивийн орнуудаас Япон, Сингапур улсууд эдийн засгийн инновацийг дэмжих үүднээс илүү уян хатан хандаж байна. Үүнээс Япон улсын хувьд 2016 онд виртуал валютыг зохицуулах хуулийг баталсан бөгөөд Японы Санхүүгийн үйлчилгээг зохицуулах агентлагаас виртуал хөрөнгийн үйлчилгээг хүлээн зөвшөөрсөн. Оросын Холбооны Улс 2020 онд Дижитал санхүүгийн хөрөнгө, дижитал валютын тухай хуулийг баталж 2021 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Харин Бүгд Найрамдах Хятад Ард Улсад крипто валютын үйл ажиллагааг хориглосон байна. Мөн БНСУ, Япон, Австрали, Англи, Швейцар зэрэг орнуудад виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид нь Санхүүгийн Зохицуулах Хорооноосоо зөвшөөрөл авсанаар тодорхой хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Монгол Улсад одоогийн байдлаар цөөн тооны виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд иргэд олон улсын

банкны картаа ашиглан гадаадын цахим флатформоор крипто валютын арилжаанд оролцох болсон. Мөн өнгөрсөн хугацаанд виртуал хөрөнгөтэй холбоотой гэмт хэргүүд хууль сахиулах байгууллагуудад бүртгэгдэх болсон нь бид энэхүү салбарын зохицуулалтыг бий болгох шаардлагыг илтгэж байна.

Цаашид юу хийх хэрэгтэй вэ?

Монгол Улсын хувьд ФАТФ-ын шаардлагыг биелүүлж Зөвлөмж 15-ын үнэлгээг ахиулах, виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, хяналт зохицуулалтын тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд Санхүүгийн мэдээллийн алба, Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран “Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”-ийн төслийг боловсруулаад байна. Энэ хуулийн төсөл нь ФАТФ-ын шаардлагад нийцүүлэн виртуал хөрөнгө болон виртуал хөрөнгийн үйлчилгээг тодорхойлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч, түүний үйл ажиллагаанд баримтлах зарчим, тавигдах шаардлага, бүртгэх, хяналт тавих, холбогдох эрх, үүргийг тусгаж, хамтын ажиллагаа, хариуцлагын тогтолцоог бүрдүүлхийг зорьсон.

“Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хууль”-ийг баталснаар виртуал хөрөнгийн хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, ФАТФ-ын техник хэрэгжилтийн зөвлөмжийн стандартыг хангах ач холбогдолтой юм.



ХЯТАДЫН БАНКНЫ САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ, ХӨГЖИЛ

Эх сурвалж: Reuters

Монгол Улсын банкны салбарт томоохон шинэчлэл хийгдэж Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан БНХАУ-ын санхүүгийн шинэчлэлийн талаарх судалгааны тайлангын “Банкны салбарын шинэчлэл” хэсгийг орчуулан уншигчиддаа толилуулж байна.

Хятадын нэрт улс төрч Дэн Шаофинг “Банк л бол банкны бүхий л үйл ажиллагааг явуулах ёстой. Гэтэл банкууд ийм байж чадахгүй байна. Тэд нягтлан бодогчид, бэлэн мөнгөний машин болчихож. Валют сольдог л газар болж” гэж тухайн үеийн банкны салбарыг шүүмжилсэн байдаг. 1978 оноос өмнө Хятад улсад зөвхөн нэг тогтолцоот банкны систем үйлчилж Хятадын Ардын Банк дангаараа Төв болон арилжааны банкны үүргийг хамтад нь гүйцэтгэдэг байсан. Тухайн үед Хятад улсын нийт санхүүгийн 93% нь тус банкны мэдэлд байлаа.

Банкны салбарын шинэчлэл хийх анхны алхам бол томоохон арилжааны банкуудыг байгуулах явдал байсан. Улмаар 1979 онд Хятадын Хөдөө Аж Ахуйн банкыг (АВС) байгуулж хөдөө, орон нутагт чиглэсэн үйл ажиллагааг явуулах болжээ. Тухайн жилд мөн Хятадын банк (ВРС) Хятадын Үйлдвэрлэлийн банк (ССВ) Хятадын Ардын банк, Сангийн яамнаас гарч, олон улсын худалдаа, томоохон хөрөнгө оруулалтын төслүүдийг санхүүжүүлж эхэлжээ. 1984 онд Хятадын Ардын банкнаас Хятадын Худалдаа, Аж Үйлдвэрлэлийн банк (ICBC) байгуулагдаж тусдаа арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх болсон байна. Энэ бол “Том-4” банкны эхлэл байв.

Мэдээж арилжааны банк олон чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан боловч улс орны эдийн засгийн хөгжилд шаардагдах санхүүгийн хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байв. Иймд банкны системд өрсөлдөөнийг бий болгох, санхүүжилт хэрэгцээтэй бусад салбарыг хөгжүүлэхийн тулд банк бус санхүүгийн байгууллагуудыг байгуулж эхэлсэн. Үүнд:

- 1980- Хувэй мужид анхны Орон нутгийн зээлийн сан үүссэн;
- 1981- Хятадын Түрээсийн Компани байгуулсан;
- 1984- Хятадын Ардын Банкнаас Ард Даатгалын Компани байгуулагдсан;
- 1986- Анхны Хамтарсан Хувьцаат Арилжааны Банк бий болсон;

1987- Анхны Хамтарсан Санхүүжилттэй Арилжааны банк үүссэн;
1994- “Том 4” банкнаас (ABC, BOC, CCB, ICBC) бодлогын 3 банк байгуулагдсан.

Ингээд 2008 он гэхэд банк, санхүүгийн байгууллагын тоо 5600 хүрсэн бөгөөд үүнд бодлогын 3 банк, Төрийн өмчит арилжааны 4 банк /Том 4/, Харилцааны банк, хамтарсан хувьцаат 13 банк, Хотын Арилжааны 136 банк, Орон нутгийн зээлийн 4965 сан болон санхүүгийн зээлийн үйлчилгээ зэрэг бусад олон байгууллагууд багтана.

Хэдийгээр банкны салбарын шинэчлэл хийгдэж 6000 орчим санхүүгийн байгууллагууд бий болсон боловч “Том 4” банк энэхүү талбарт давамгайлсан хэвээр байв. Урт хугацаанд оршин тогтнож, орон даяар өргөн тархсан салбаруудын давуу талууд нь үүнд нөлөөлж байв. 1996-2008 онд хөрөнгө, хадгаламж болон зээлийн аль ч үзүүлэлтээр банкны салбарын 60 гаруй хувийг эдгээр “Том 4” банк эзэлж байв. Энэ үзүүлэлт 1978-1995 онуудад илүү өндөр хувьтай байсан. (Хүснэгт 3).

Хүснэгт 3. 1978-2008 ДундажХарьцаа (%)

	1978-1995			1996-2008	
	Deposits	Loans	Assets	Deposits	Loans
Том-4	81.98	91.07	65.11	64.64	64.22
12 Хамтарсан хувьцаат арилжааны банк	1.47	1.22	14.88	15.37	15.80
Хотын Арилжааны Банк	1.93	0.95	6.57	6.60	6.63
Орон нутгийн банк болон сангууд	18.12	6.34	11.73	11.66	11.6
Гадны банк	0.18	0.43	1.71	1.74	1.76

Эх сурвалж: Жилийн санхүүгийн тайлан. /Хятад/

(1). “Том - 4” банкны шинэчлэл

Нэг шатлалт банкны системээс эхлэлтэй энэхүү шинэчлэл нь 1984 онд 2 шатлалт системийг бий болгож, улмаар санхүүгийн олон төрлийн үйлчилгээний үр дүнд санхүүгийн байгууллагыг төрөлжүүлсэн төдийгүй гүйцэтгэлийн үзүүлэлтийн тоог ч нэмэгдүүлж чадсан.

“Том 4” банк Төрийн өмчит аж ахуйн нэгж /ТӨААН/-ийг сэргээхэд төдийгүй Хятад улсын санхүүгийн системийн тогтвортой байдалд үнэтэй хувь нэмэр оруулсан. Гэсэн хэдий ч түүхэн хугацаанд тэд их хэмжээний өр болон эрсдэлийг бий болгосон. Жишээлбэл, Азийн санхүүгийн хямралын үед тэдний чанаргүй зээлийн эзлэх хувь маш өндөр, өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа буурсан, компаний засаглал сул мөн эрсдэлийн удирдлагын чадваргүй байсан. Тухайн үед зарим олон улсын шинжээчид “Том 4”-ийг төлбөрийн чадваргүй болсон гэх дүгнэлтийг өгч байсан. (Ларди 1998).

Арилжааны банкны зээлийн 90 гаруй хувь нь ТӨААН-д олгодог байсан учраас ТӨААН-ийг шинэчлэхээс нааш “Том 4”-т шинэчлэл хийх ямар ч боломжгүй байв. ТӨААН-ийг санхүүжилтээр хангах нь банкны улс төрийн шинжтэй үүрэг байсан учир банкууд бусад аж ахуйн нэгж болон төслүүдэд зээл олгох боломж хязгаарлагдмал байв. Иймд, ТӨААН-д оруулсан өөрчлөлтүүд нь банкны шинэчлэлийг бий болгоход таатай нөхцөлийг бүрдүүлж өгчээ.

Үүний дараа Засгийн газар “Том 4”-т шинэчлэл хийхээр шийдсэн боловч энэ нь тийм ч амархан даваа биш байлаа. Түүхэн хугацаанд үүссэн асуудлууд төдийгүй бодлогын чанартай зээлийн нөхцөлүүдээс зугтах боломжгүй байв.

Энэ мэт хүндрэлүүдээс үүдэн эрх баригчдын зүгээс хамтын хөрөнгө оруулалтын банк байгуулах замаар шинэ санхүүгийн байгууллагуудыг бий болгоход анхаарч эхэлсэн. Ингэснээр шинээр байгуулагдаж буй банкууд “Том 4”-ийн шинэчлэлийг хийхэд түлхэц болно гэж үзжээ. (Лиү 2009а). 1986 онд анхны хамтын хөрөнгө оруулалттай банк болох Харилцааны Банк байгуулагдсан. Үүний дараа 1987 онд анхны групп компанийн хөрөнгө оруулалттай CITIC Үйлдвэрлэлийн Банкыг байгуулсан. Одоогоор нийт 13 хамтын хөрөнгө оруулалттай арилжааны банк байгаа бөгөөд үүнээс 8 нь хөрөнгийн захад бүртгэлтэй байна.

Эдгээр хамтын хөрөнгө оруулалттай арилжааны банкууд байгуулагдсанаар өмчийн эрхийн байдал, бизнесийн төрөлжилт, эрсдлийн удирдлага болон дотоод хяналтын систем зэрэг асуудлуудыг тодорхой болгож чадсан. Гэсэн хэдий ч “даварсан” 4 банкыг дарж авахад хангалттай үүрэг, нөлөө үзүүлж чадсангүй. Засгийн газраас дахиад л өөр арга хайх шаардлагатай боллоо. Үүний тулд “Том 4”-өөс бодлогын зээлийг салгаснаар ачааллыг нь тодорхой хэмжээнд бууруулж шинэчлэл хийх суурийг тавсан юм. Ингэж бодлогын 3 банк 1994 онд байгуулагдсан.

1997-1998 онуудад болсон Азийн хямрал нь “Том-4”-ийн шинэчлэл хийхэд саад болж байлаа. Олон улсын эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсан энэ үед Хятадын гадаад худалдаа сэргэж харин хүүгийн түвшинг бууруулах боломж хумигдсан. “Том 4”-өөс урт хугацаанд харилцаатай явж ирсэн ТӨААН-үүдийн санхүүгийн эрсдэлийг Засгийн газар үүрэх шаардлага үүссэн. 1998 онд Засгийн газраас 270 тэрбум юанийн тусгай бонд гаргаж “Том-4” арилжааны банкуудын хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

1999 онд, АНУ-ын Resolution Trust Corporation (RTC)-ийн туршлага дээр үндэслэн Хятадын Засгийн газар хөрөнгийн удирдлагын компаниудыг (АМС) байгуулж “Том-4”-т байсан чанаргүй зээлийн активыг удирдах, зохицуулах арга хэмжээг авсан. Үр дүнд нь, Хятадын Синда, Хуаронг, Ориент, Цагаан хэрэм гэх хөрөнгө удирдлагын корпорациуд бий болж ССВ, ICBC, BOC болон ABC гэсэн “Том-4” банкны чанаргүй хөрөнгийг шилжүүлэх зохицуулалт хийсэн байна. Дээрх 4-н том Хөрөнгө Удирдлагын Корпораци нийт 1,4 тэрбум юанын чанаргүй хөрөнгийг 1999 онд шилжүүлэн авсан байна.

Хөрөнгийн тодорхой хэсгийг салган авсан ч гэсэн ТӨААН-ийн асуудлыг үндсээр нь шийдвэрлэхэд нөлөө үзүүлж хараахан чадсангүй. Хуучин тогтолцооны үед байсан ачаа дарамтууд бүрэн арилсан боловч шинэ эрсдлүүд бий болсоор л байв. 2004 оны эхний улиралд “Том-4” банкны чанаргүй зээл 19.15% хувьд хүрсэн. 1995-2007 онуудын хугацаанд энэ үзүүлэлт тогтвортой буурч байсан бөгөөд ерөнхий дундаж нь 12,9% орчим байхад бусад арилжааны банкуудын дундаж 3,95% орчим л байв.

Чанаргүй зээлийг шилжүүлэх шийдвэртэй зэрэгцээд Засгийн газраас арилжааны банкуудын зээлийн төрөлжилтийн системийг өөрчилж 4 байсныг 5 болгож нэмэгдүүлэх шаардлага тавьсан. Энэхүү зээлийн төрөлжилтийн шинэ систем нь ихэвчлэн хөгжсөн орнуудад хэрэгжиж байв. Нөгөө талаар энэ систем нь урагшаа харсан бөгөөд зээлийн эрсдлийн үнэлгээг тооцож, тухайн зээлдэгч үндсэн зээл болон хүүгийн төлбөрийг төлөх чадварт суурилан үнэлгээ өгдөг бол өмнөх 4 төрөлт систем нь зээлдэгчийн эрсдлийг тооцоолдоггүй, хоцрогдсон систем байсан юм.

2001 оны 12 дугаар сард гарсан удирдамжийн дагуу, энэхүү шинэ зээлийн ангилалын систем нь “Том-4” банкуудын үндсэн салбаруудад хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2002 оноос бусад бүх банкуудад албан ёсоор хэрэгжихээр заасан байна. Энэ нь банкны зээлийн чанарыг сайжруулж цаашид банкны тогтвортой, ил тод байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн болов уу.

Нягтлан бодох бүртгэлийн систем шинэчлэгдсэн нь банкны үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлж, зээлийн ангилалыг илүү бодит болгосон. 2002 оны 1 дүгээр сард Сангийн Яамнаас “Санхүүгийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн систем”-ийг баталсан. Шинэ бүртгэлийн системийн дагуу тухайн зээлийн хүүг хуримтлуулах эсэх шийдвэрийн хугацааг олон улсын стандартын дагуу 90 хоног болгож бууруулсан.

Хятад улс Дэлхийн худалдааны байгууллагад нэгдэж улмаар санхүүгийн салбараа тэлэхийн тулд банкны салбарт яаравчилсан суурь шинэчлэл хийсэн. Өмнө нь “Том-4” банкны бүртгэлээс муу хөрөнгийг нь шилжүүлсэн явдал бол зөвхөн асуудлын шинж тэмдгийг нь дарсан явдал байсан. 2003 он гэхэд Засгийн газар эдгээр банкны эзэмшлийн асуудлыг хөндөхгүйгээр цааш явах боломжгүй гэдгийг ойлгосон юм.

2003 оны сүүлчээр ВОС болон ICBC банкууд хамтын эзэмшлийн арилжааны банк болох үүд хаалгаа нээсэн. Тэд тус бүр 22,5 тэрбум юаны хөрөнгө босгосон. Гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид ч мөн гарч ирсэн. 2006 онд ВОС хамгийн түрүүнд дотоод (Шанхай) болон гадаадын (ХонгКонг) бүртгэлтэй компани болсон. Удалгүй үүний дараа 2006 онд ICBC, 2007 онд CCB, 2010 онд ABC банкууд тус тус хувьчлагдсан. Одоо “Том-4” банк бүгд давхар бүртгэлтэй буюу Шанхай болон Хонконгийн захад үйл ажиллагаа явуулж байна.

Нээлттэй хувьцаат компани болгож эдгээр банкны үр ашгийг сайжруулахын тулд Засгийн газраас дараах 4 арга хэмжээг авсан байна. Үүнд: хөрөнгө босгох, санхүүжилт босгохын тулд бага эрэмбэтэй бонд гаргахыг хүлээн зөвшөөрөх, чанаргүй зээлийг Хөрөнгийн Удирдлагын Корпорациар дамжуулан шилжүүлэх, гадаадын стратегийн хөрөнгө оруулагч нарыг оруулж ирэх явдал байв. (Оказаки, 2007).

Хүснэгт 4. Шинэчлэлийн дараах тоо баримт

Банк	ICBC	ВОС	CCB
Бүртгэгдсэн огноо	Oct. 28, 2005	Aug. 26, 2004	Sept. 17, 2004
Хөрөнгө нийлүүлэлт: Хэмжээ (RMB тэр бум)	124.0	186.4	186.2
Огноо	Apr 2005	Dec 2003	Dec 2003
Доогуур үнэлгээтэй бондын даатгал (RMB тэрбум)	35.0 [2005]	26.0 [2004], 34.0 [2005]	40.0 [2004]
[огноо] ^{b)}			
Чанаргүй зээлийн шилжүүлэлт (RMB тэрбум) ^{c)}	705.0	308.1	185.8
Гадаа стратегийн хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын хэмжээ (RMB тэр бум)	30.5	43.0	32.8

Гадаадын хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь 2006.6.30-ны байдлаар	8.4	14.1	14.4
IPOs: Хөрөнгийн Өсөлт (%)	44	46	36
IPOs: Хэмжээ (RMB тэр бум)	173.2	110.0	74.6

Эх сурвалж: Оказаки, 2007

Энэ хугацаанд гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид орж ирсэн бөгөөд төрийн өмчид арилжааны банкуудыг хэсэгчлэн хувьчлах үйл ажиллагаа өргөн дэлгэрсэн. Үүний тод жишээ бол 2005 оны 6 сарын 17-нд Америкийн банк (Bank of America) нь CCB банкны 9%-ийг худалдаж авахаар шийдвэрлэсэн, мөн тухайн жил Темасек (Temasek) хөрөнгө оруулалтын компани тус банкны 5,1%-ийг авахаар 1,5 тэрбум америк долларын хөрөнгө оруулахаар болсон байна. 2005 оны 9 сард Шотландын Роял Банк (Royal Bank of Scotland) болон Темасек нар хамтран ВОС-ийн 10 хувийг худалдаж авахаар шийдсэн байна.

Засгийн газраас гадаадын стратегийн хөрөнгө оруулагчид өөрсдийн хувьцааг 3 жилийн хугацаанд түгжих шаардлага тавьдаг байв. Гэвч эдгээр хөрөнгө оруулагчдын авчирсан зүйл зөвхөн хөрөнгө төдий зүйл биш байсан. Үүнээс илүүтэйгээр тэд ажилчдыг чадавхжуулах, эрсдэлийн удирдлагыг бэхжүүлж, корпорацийн удирдлага болон дотоод хяналтыг сайжруулахад хувь нэмэр оруулсан. (Berger et al. 2005b).

Хэдийгээр төрийн эзэмшил өндөр хэвээр байсан боловч олон нийтэд гарсан нэг том давуу тал нь эзэмшлийн бүтцэд өөрчлөлт оруулсан явдал байлаа. Түүнчлэн мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлсэн нь бас нэгэн том нөлөө болж чадсан. Гадаадын санхүүгийн байгууллагууд тайлан, тэнцэлтэй танилцах шаардлага гарсан учир мэдээлэл илүү хурдан, тодорхой болж чадсан.

Эдгээр банкууд дахин зохион байгуулалтад орсны дараа удирдлагын тогтолцоонд эрс өөрчлөлтийг авчирч чадсан. Олон улсад хөрөнгийн зах зээл ганхаж байх үед ICBC, CCB болон ВОС банкууд 2009 он гэхэд дэлхийн хөрөнгийн захад хамгийн шилдэг 3-т эрэмблэгдэж байлаа. Мэдээж энэ нь дэлхийн санхүүгийн байгууллагууд дунд хамгийн шилдэг нь болчихсон гэсэн үг хараахан биш юм. Гэвч эдгээр банкууд дэлхийн томоохон банкуудтай нийт актив, хөрөнгийн хэмжээгээрээ өрсөлдөхүйц байж чадсан. Гэвч активийн чанар болон ашгийн үзүүлэлтээр Хятадын банкууд сайжруулалт хийх шаардлага байсаар байв.

Банкуудын активын өгөөж болон Өөрийн хөрөнгийн өгөөж гэсэн гол үзүүлэлтүүд 2005 оноос хойш өсөлттэй хэвээр байгаа. (Хүснэгт 5). Гэвч ашгийн эх үүсвэрийн бүтэц тэнцвэргүй хэвээр байна. Банкууд зээлийн хүүнээс ашиг олоход илүү төвлөрч харин хөрөнгө босгох бизнес хөгжөөгүй хэвээр байв. (Хүснэгт 6).

Хүснэгт 5. Ашгийн үзүүлэлтүүд, 2005-2009.

	ROAA				
	2005	2006	2007	2008	2009
ICBC	0.66	0.71	1.02	1.21	1.20
ABC	0.02	0.10	0.82	0.84	0.82
BOC	0.70	0.96	1.10	1.02	1.09
CCB	1.11	0.92	1.15	1.31	1.24
HSBC	1.56	1.62	1.99	1.34	1.18
	ROAE				
	2005	2006	2007	2008	2009
ICBC	-27.92	13.65	16.21	19.34	20.13
ABC	1.32	6.40	-13.60	-23.55	20.52
BOC	13.06	14.44	14.37	14.01	16.60
CCB	19.49	14.99	18.38	20.82	20.81
HSBC	23.82	22.58	25.00	17.51	15.32

Эх сурвалж: BankScope.




Базелийн хорооноос Олон улсын Хөрөнгийн Удирдлагын Нэгдсэн Стандартыг шинэчилэн Basel II стандартыг 2004 онд гаргасан. Basel I стандартын дагуу санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд банкны эрсдлийн удирдлагыг сайжруулж хөрөнгийн хэмжээг хангалттай түвшинд нэмэгдүүлэх шаардлага хэвээр байлаа.

Үүний үр дүнд Хятадын томоохон арилжааны банкууд буюу гадаад зах зээлд үйл ажиллагаагаа явуулдаг банкууд 2010 оны сүүл гэхэд Basel II стандартыг нэвтрүүлсэн байхыг шаардсан. Харин жижиг, дунд түвшний арилжааны банкууд сайн дураараа энэхүү стандартыг хэрэгжүүлэхийг зөвлөсөн юм.

Эх сурвалж: https://www.paftad.org/files/34/07_HUANG_Fin%20Reform_nofig.pdf

Financial Reform in China: Progresses and Challenges # Yiping Huang, Xun Wang, Bijun Wang and Nian Lin China Macroeconomic Research Center, Peking University, China First Draft: 29 November 2010, Pages 27-33.

ТҮҮХИЙ ЭДИЙН ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭ (АМ. ДОЛЛАРААР, 29/1 ӨДРИЙН БАЙДЛААР)



“VELOCIRAPTOR” ФРАНЧАЙЗ ДУРСГАЛЫН ЗООС

Жин: 93.3 гр

Металл: Мөнгө. 999

Хэмжээ: 65 мм

Нэрлэсэн үнэ: 2000 төгрөг



Монгол улсын Эрт галавын үеийн араатан цувралын “Velociraptor” франчайз зоос “Шилдэг технологи” төрөлд III байр эзэлж байжээ. Энэхүү дурсгалын зоос нь Эрт галавын үеийн араатны цувралын хамгийн анхны франчайз зоос бөгөөд 65 мм диаметртэй, 93,3 гр жинтэй юм.



“Velociraptor” дурсгалын зоос



Б.МЭДРЭЭ: ХОЁР ШАТЛАЛТ БАНКНЫ ТОГТОЛЦОО НЬ МОНГОЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД КАТАЛИЗАТОРЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН

Монголын Банкны Холбооны Ерөнхийлөгч Б.Мэдрээтэй 2021 оны 2 дугаар сарын 3-ны өдөр ярилцлаа.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн 100 хувь төрийн мэдэлд байсан банкны систем 1990 оноос хоёр шатлалт банкны тогтолцоо руу орсон. Хоёр шатлалт банкны үйл ажиллагаа, зорилго чиглэлийг тухайн үед хэрхэн харж, зорьж байсан бэ? Хоёр шатлалт банкны тогтолцоо бий болсноор эдийн засаг, нийгмийн хөгжилд хамгийн гол ач холбогдол нь юу байв?

1990 онд Монгол Улсын улс төр, эдийн засгийн тогтолцоо ямар байсан бэ гэдгээс эхлээд ярья. Тухайн үед улс төрийн хувьд дөнгөж ардчилсан тогтолцоо руу алхаад орчихсон. Харин эдийн засгийн хувьд зах зээлд бүрэн ороогүй, нийгмийн хувьд социалист сэтгэл зүйгээс салаагүй байсан.

Банкны салбар зах зээлд реформ хийж орсон хамгийн анхны салбаруудын нэг. Өөрөөр хэлбэл, банкинд ажилладаг хүмүүс банкны нэг шатлалт тогтолцооноос хоёр шатлалт тогтолцоо руу орох талаар мэр сэр ярьж байсан. Хамгийн анх Худалдаа, хөгжлийн банкийг Д.Сүх-Эрдэнэ, Н.Жаргалсайхан, Н.Золжаргал бид дөрөв үүсгэж байлаа. Тухайн үеийн Улсын банкны Ерөнхий хорооны дарга Г.Хүдэрчулуун албан тоот бичиж, Сайд нарын зөвлөлд оруулснаар 1990 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 70, 71 дүгээр тогтоолоор Худалдаа, хөгжлийн банк болон ХОТШ банкууд үүсгэн байгуулагдсан байдаг. Харин Банкны тухай хуулийг үүнээс хойш 1991 оны дөрөвдүгээр сарын 4-нд Улсын

бага хурлаар баталсанаар Монгол Улсад Төв банк ба арилжааны банк гэдэг тогтолцоо үүсэж бий болсон.

1990 он хүртэл иргэд хувьдаа зээл авч болдог гэсэн ойлголт байгаагүй. Хууль, эрх зүйн орчин ч байгаагүй. Тэр үед аж ахуй, нэгдэл, үйлдвэрийн газруудад төрөөс зээл олгодог байсан. 1990 оноос хувьчлал эхэлж байсан болохоор банкнаас зээл авдаг аж ахуйн нэгж, албан байгууллагын тоо ч дэндүү цөөхөн байсан. Тэгэхээр зээл маш бага гарч байсан. Өнөөдөр Монголд 1.3 сая гаруй зээлийн данс идэвхтэй байна. Энэ тоо 2008 оны байдлаар гэхэд 500 мянга гаруй л байсан. Тэгэхээр өнөөдөр зээлгүй хүн гэж бараг байхгүй болсон. Бүгдээрээ зээлтэй болоод эхлэхээр зээл олгох мөнгөний хэмжээ дутаад эхэлсэн. Тийм учраас хүү өндөр байна гэдэг шүүмжлэл өрнөж байгаа. Зээлийн хүү ямар байх нь маш олон хүчин зүйлээс шалтгаалдаг зүйл.

Социализмын үед бид сүү, махнаас эхлээд маш олон зүйлд оочерлодог л байсан. Гэтэл арилжааны банк бий болж, зээл олгоод эхлэнгүүт энэ нь нийгмийн хөгжилд катализатор болсон. Нийгмийн хөгжлийг хурдан, түргэн болгож өгсөн гэсэн үг. Ингээд Монголын нийгэм, хүмүүсийн аж амьдралыг маш хурдацтайгаар өөрчилж эхэлсэн.

Хэдийгээр арилжааны банк бий болсноор нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан ч үүний нөгөө талд банкны тогтвортой байдал чухал. Өнгөрсөн хугацаанд нийтдээ 24 банк дампуурсан байна. Үүний гол шалтгаан нь юу байв?

Зах зээлийн эдийн засаг гэж юу вэ гэдгийг Монгол Улс даяараа, төр нь, иргэд нь хүртэл ойлголтгүй байсан гэхэд хилсдэхгүй. Дээрээс нь дөнгөж банк үүсч байгаа учраас хууль, эрх зүйн тогтолцоо нь нялхаараа. Технологи нь маш муу түвшинд, боловсон хүчний мэдлэг, боловсрол, ёс суртахуун, чадвар чансаа нь сайн байгаагүй. Ийм нөхцөлд бид үндсэндээ усанд сэлж чаддаггүй хүүхдийг ус руу түлхээд оруулчихсан. Ингээд сэлж сурч эхэлсэн. Хууль, эрх зүйн тогтолцоо л гэхэд өнөөдөр Монгол Улсад 730-аад хууль үйлчилж байгаагийн 70 орчим нь банкны системтэй холбоотой хууль байна. Тэр үед ийм 70 орчим хууль байгаагүй. Банкны хууль дөнгөж л 1991 онд батлагдсан шүү дээ. Мөн хууль, эрх зүйтэй холбоотой заавар, журам бүрэн боловсруулагдаж, мөрдөгдөж, хэрэгжиж байгаагүй. Үүнээс болоод буруу зээл олгох, барьцаа баталгаа хөрөнгийг буруу тооцоолох, эсвэл бүр тооцоо судалгаагүй, танил талаараа зээл олгох гэх зэрэг асуудал үүсч, үр дүнд нь банкууд дампуурч эхэлсэн байдаг. Товчхондоо, маш их алдаа, эндэгдэл, бэрхшээл дундуур банкны сектор “сэлсээр” өдийг хүрсэн. Банкирууд өөрсдөө ч бизнес гэдгийг ойлгоогүй, явцын дунд л суралцсан.

Гэтэл ...?

Гэтэл банкны программ хангамж олон улсын стандартад нийцдэг болсон. Базелийн хорооны шалгуур үзүүлэлтүүдийг Төв банк хэрэгжүүлж эхэлсэн. Олон улсын нягтлан бодох бүртгэлийн, засаглалын, мэдээллийн аюулгүй байдлын стандартыг нэвтрүүлсэн. Аудит, үнэлгээ хийлгэдэг боллоо. Свифт гэж төлбөр тооцооны олон улсын стандартын систем орж ирсэн. Карт гэдэг зүйл орж ирлээ. Энэ утгаараа банкууд хамгийн эрчимтэй автоматжуулагдсан, цахимжсан салбар болж ирсэн. АТМ, пос терминал, онлайн, мобайл банк гэх зэрэг технологиуд нэвтэрсэн. Одоо хиймэл оюун ухааныг нэвтрүүлэх эхлэл тавигдаж байна.

Тэр хэрээр Банкны тухай хуульд олон өөрчлөлтүүд орж байсан байх?

Банкны тухай хуулиас гадна Төв банкны хууль батлагдлаа. Өнөөдөр Монголын Төв ба арилжааны банкуудад нийтдээ 70 гаруй хууль хэрэгжиж байна. Алхам алхмаар банкны хууль эрх зүйн орчин сайжирч, боловсронгуй болж байгаа.

Гэхдээ Монгол Улсын санхүүгийн салбар, арилжааны банк гэдэг нэг л хөлтэй байгаад байна. Өнөөдрийг хүртэл яагаад ийм их төвлөрөл зөвхөн банкинд дээр бий болчихов?

Иргэний хуулиар, иргэд хооронд зээл олгож болно. Хуулийн хүрээнд арилжааны банк, ББСБ, ХЗХ, Барьцаалан зээлдүүлэх буюу ломбард зээл олгож болно. Мөн байгууллага хооронд зээл олгож болно. Олон улсын банк, санхүүгийн байгууллагууд буюу ОУВС, Дэлхийн банк, АХБ-ны зүгээс Монголын арилжааны банкинд янз бүрийн техникийн туслалцаа, дэмжлэг их өгч байсан нь нэг учир шалтгаан болох байх. Нөгөө талаас Монголд хэдийгээр хөрөнгийн бирж байгуулагдсан ч хувьцаат компани болохын ач холбогдол, давуу талыг Монголчууд өнөөг хүртэл сайн ухамсарлаагүй байна. Ихэнх компаниуд өнөөдрийг хүртэл ХХК хэлбэртэй л байна. Тэр хэрээр хөрөнгийн зах зээлийн хөгжил хурдацтай явж чадаагүй. 2021 оны нэгдүгээр сарын 28-нд банкуудын хувьцааны төвлөрлийг сааруулах зорилгоор Банкны хуульд нэмэлт, өөрчлөлт орууллаа. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш 30 жилийн дараа л ийм хууль батлагдаж байна. Системийн ач холбогдолтой банкууд нээлттэй хувьцаат компани болж, ард иргэд хувьцаа эзэмшигчид болно.

Хөрөнгийн бирж дээр сайн бүтээгдэхүүн гарах тусам зах зээлийн багтаамж нь тэлж хөгжих боломжтой гэж Х.Алтай захирал хэлсэн байсан?

Тийм. Гэхдээ бас тогтолцоог нь зөв хийх хэрэгтэй байна. Бүгдээрээ ХХК байж болохгүй. Зарим салбарт төвлөрлийг сааруулж, нээлттэй ХК болгох бодлогыг төрөөс зохицуулж оролцож байгаа. Энэ нь байх ёстой зүйл. Үйл ажиллагаанд нь бус тогтолцоонд нь төрөөс оролцож, зохицуулалт хийж байна гэсэн үг.

2018 оноос хойш банкуудад эрчимтэй шинэчлэл хийж эхэлсэн. Энэ нь банкуудад ямар сайн нөлөө үзүүлж байна вэ?

Гэхдээ банкны реформ Монголын хувьд харьцангуй удаашралтай явагдаж байна.

1929-1932 онд Америкт их хямрал болсны дараа тухайн үеийн АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельт маш хурдацтайгаар банкны реформыг эхлүүлсэн байдаг. Рузвельт өөрөө энэ шинэчлэлийг удирдаад, “Харилцах дансанд хүү төлөхийг хориглоно” гэдэг зүйл заалтаас эхлээд л хууль эрх зүйн шинэчлэлийг маш богино хугацаанд хийсэн. Сая “Ковид-19” гарах үед БНХАУ 10 мянга орчим заавар, журамдаа аравхан хоногийн дотор өөрчлөлт оруулсан. Яг үүнтэй адилаар банкны секторт үйлчилж байгаа 70 гаруй хууль, 270 гаруй журам зааварт УИХ-аас ажлын хэсэг гаргаад, маш олон дэд ажлын хэсгүүдийг байгуулаад, богино хугацаанд реформ хийгээсэй гэж мөрөөддөг. Өнөөдөр Монголын банкны салбарт үйлчилж байгаа хууль, тогтоомжууд дотор банкны зардлыг нэмэгдүүлж байгаа зүйл заалтууд маш олон бий. Наад зах нь банк болгон тусдаа АТМ, пос - терминалтай байна шүү дээ. Уг нь хуулиар зохицуулаад өгвөл энэ мэт үйлчилгээг дундын компани байгуулснаар зардлыг хэмнэх боломжтой. Мөн банкууд аль болох цахимжсан банк болох хэрэгтэй гэдэг нь энэ цаг үед маш тодорхой харагдаж байна.

Ковид-19 зэрэг хямралтай холбогдуулаад асуухад цаашдаа дахиад үүн шиг хямрал ирэх үед банкны салбар хэрхэн бэлтгэсэн байх ёстой вэ?

Хямралын үед банкууд ямар арга хэмжээ авах ёстой вэ гэдгийг 2008 оны хямралын үеэр л дэлхий нийт ойлгосон. Тэрнээс өмнөх 100 гаруй жилд дэлхий нийт яг юу хийх ёстой вэ гэдгийг бүрэн ойлгоогүй байсан. Хямралын үед ерөөсөө л Төв банкны уламжлалт бус арга хэрэгслийг ашиглах арга юм. Үүнээс өмнө Шведийн Төв банк, Японы Төв банк зарим нэг оролдлогыг хийсэн байдаг ч тодорхой амжилтанд хүрээгүй. Харин 2008-2010 оны хямралын үед Төв банкуудаас авсан арга хэрэгсэл нь шууд үр нөлөөгөө өгсөн. Тэгэхээр мөнгөний зөөлөн бодлого, уламжлалт бус бодлого хэрэгжүүлэх л асуудал юм. Төв банк нь Арилжааны банкууддаа бараг 0 хувийн хүүтэй, хангалттай хэмжээний, хангалттай хугацаатай

зээл өгсөн. Арилжааны банкууд нь харилцагчдадаа зээл олгосон. Үр дүнд нь үйлдвэрүүд хаагдаагүй, ажилчдаа халаагүй, борлуулалтаа хийсэн. Үүнийгээ “мөнгөөр хана хэрэм барих” гэж нэрлэсэн. Өнөөдөр тийм бодлого манай Төв банк мэр сэр хэрэгжүүлж байна. Уламжлалт бус бодлого гэхээр 7-8 арга бий. Бүгд өөр өөрийн онцлогтой. Өөр өөрийн гэсэн зарчим, арга зүйтэй. Мэдээж бүгдийг нь манай Төв банк судалж байгаа байх. Хямрал хэзээ ирэхийг хэн ч хэлж чадахгүй. Гэхдээ түүнд бэлэн байхаар хууль эрх зүйн баримт, бичгүүддээ өөрчлөлт оруулсан байх ёстой. Одоо арилжааны банкуудаа мөнгөжүүлэх Төв банкны бодлого хэрэгтэй. Тодорхой хугацааны, чиглэсэн зорилготой мөнгөжүүлэх бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

Ингэснээр мөнгөний хэмжээ нэмэгдэж, хадгаламжийн хүү буурна. Үүнийг зоригтой хийх хэрэгтэй.

Мэдээж бидэнд мөнгө хэрэгтэй. Одоогийн түвшинд экспорт маань нэг салбараас л хамааралтай. Эдийн засгийг солонгоруулах талаар Таны бодол ...

Би солонгоруулах гэж ярих дургүй. Төрөлжүүлэлт буюу диверсификаци гэж ярих хэрэгтэй. Тараан байршуулах гэсэн үг шүү дээ. Жишээ нь, Та хадгаламжиндаа 100 сая төгрөгтэй байлаа гэхэд 100 сая төгрөгөө 5 банкинд, 5 хувааж байршуулбал, аль нэг банк нь санхүүгийн хүндрэлд орлоо гэхэд бусад нь хэвийн л байна. Үүнийг тараан байршуулалт гэж байгаа юм. Үүнтэй адилаар эдийн засагт төрөлжүүлэлт хийх хэрэгтэй юм. Нефтийн аж үйлдвэртэй, зэс, төмрийн боловсруулах аж үйлдвэртэй байх хэрэгтэй. Үүнийг хийж чадвал нефтийн үнэ унаж байхад ээсийн үнэ өндөр байдаг. Ингэж төрөлжүүлэлт хийгдсэнээр макро эдийн засаг сайжирна. Түүнчлэн, бид БНХАУ-тай юаниар гэрээ хиймээр байна. Ингэвэл манай худалдааны тэнцэл ашигтай гарна. Оростой рублиэр хиймээр байна. Мэдээж алдагдалтай. Гэхдээ Орос, Хятад хоёрынхыг нэмээд үзэхээр манай нийт тэнцэл ашигтай гарна. Үүнийг төрийн түвшинд гэрээ байгуулаад, улс төрийн шийдвэрийг гаргаад, хийх ёстой. Манай улс доллараас хамааралтай, тийм болохоор валютын нөөц хангалттай бус. Валютын нөөцөөсөө хамаарч ханш нь байнга хэлбэлзэлтэй байдаг. Энэ тогтолцооноос гарах хамгийн чухал зүйл нь наймаа хийж байгаа улстайгаа тухайн улсуудын валютаар хийдэг байх хэрэгтэй. Манай наймаа хийдэг

үндсэн улсууд нь Хятад, Орос шүү дээ. Тэгэхээр үүнийг маш зоригтойгоор хийх ёстой. Үүнийг л реформ гэнэ.

Эдийн засгийг төрөлжүүлэхэд ялангуяа банкны салбарт хийгдэж байгаа реформ их үүрэг, ач холбогдолтой байх. Тухайлбал, сая банкуудыг нээлттэй хувьцаат компани болгохоор хуульчилсан. Тэгэхээр энэ салбарт өрсөлдөөн бий болж, бүтээгдэхүүн, үйлчилгээгээ төрөлжүүлэх байх. Банк нээлттэй хувьцаат компани болсноор том зургаараа эдийн засагт ямар үр ашигтай гэж үзэж байна вэ?

Мэдээж олон нийтийн хяналт бий болно. Хяналт гэдэг нь засаглал сайжирна гэсэн үг. Олон нийтийн хяналт бий болоод хөрөнгийн биржээр хувьцаа нь зарагдаад эхлэхээр томоохон хувьцаа эзэмшигчид өөрийн төлөөллөө ТУЗ-д суулгана. ТУЗ-ийн гишүүд нь аудит, бүх хяналтын байгууллагуудаа ажиллуулна.

Тэгэхээр нэг хүн дураараа дургих бололцоогүй болж, сайн засаглалын үр шим илэрнэ. Мэдээж улсын төсөв биш учраас хувийн арилжааны банкууд мөнгөө оновчтой зүйлд л зарцуулна. Системийн ач холбогдолтой банкууд хөрөнгийн бирж дээр гарах учраас тэдгээрийн үйл ажиллагааны чанар, чансаагаар нэгж хувьцааны зах зээлийн үнэ тогтоогдоно. Тийм учраас хувьцаа худалдаж авсан хүмүүс өгөөжөө хүртэнэ. Ногдол ашиг авна. Мэдээж одооноос Төв банк ноогдол ашиг хуваарилалтыг арваад жил хязгаарласнаа зогсоох шаардлагатай. Ингээд тухайн банк улс даяараа үнэлэгдэнэ гэсэн үг. Банкуудын чанар бодитоор танигдана. Зах зээлийн эдийн засгийн жам ёсны гол хууль нь өрсөлдөөн. Өрсөлдөөнөөр дамжаад эдийн засгийн үр өгөөж нь шууд мэдэгдэнэ. Дээр дурьдсанчлан, банкны сектор нийгэм, эдийн засагт катализаторын үүрэг гүйцэтгэдэг. Тэгвэл банкууд нээлттэй ХК болсноор энэхүү катализаторын хурд, хүч, нөлөө улам нэмэгдэнэ.

Тэгэхээр банкууд энэ өөрчлөлтийг таатай хүлээн авч байна гэсэн үг үү?

Яг одоогийн томоохон хувьцаа эзэмшигчид яаж хүлээж авч байгааг мэдэхгүй. Харин банкны өдөр тутмын үйл ажиллагааг хариуцаж байгаа топ менежерүүд, эдийн засагчид үүнийг маш зөв гэж хүлээн авч байгаа. Миний бие ч зөв л гэж хүлээн авч байгаа. Монголбанк үүнийг 2019 оны



мөнгөний бодлогодоо тусгаад, 2020 онд хуулийг нь боловсруулаад, 2021 онд хууль болж батлагдлаа. Тэгэхээр шат дараатай, бодлогоор хийгдэж байгаа. Тэгэхээр бодлого, тогтолцоо зөв бол цаашдын үйл явц зөв замаар явна.

Өнөөдрийг хүртэлх Монголын банкны тогтолцоог харвал хамгийн анх 1924 онд банкны тогтолцоо бий болж, 1990 онд хоёр шатлалт банкны тогтолцоо руу шилсэн. Харин одоо банкууд нээлттэй ХК болно гэхээр нэг ёсондоо Монголын банкны хөгжил гурав дахь шат руугаа шилжиж байна гэж дүгнэж болох уу?

Өмчлөлийн хувьд ингэж тодорхойлж байгаа учраас хөгжлийн хувьд нэг шинэ шатаар ахиж байна. Яг нэг, эсвэл хоёр, гурав дахь гэж хэлж мэдэхгүй. Гэхдээ банк шинэ шат руу нэг алхмаар урагшилж байна гэж ойлгох хэрэгтэй.

Мэдээж бидэнд олон улсын сайн туршлагууд хэрэгтэй байх?

Дугуй нэгэнт зохиогдсон байхад дахиж зохиох хэрэггүй шүү дээ. Хайран цаг хугацаа, зардал мөнгө биз дээ? Ингээд бодвол бид харин ч оройтсон юм биш үү? Гэхдээ хэзээ ч хийхгүй байснаас оройтоод ч болов хийсэн нь дээр.

Энэ бүгдтэй хамт санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал гэх чухал суудал байна.

Санхүүгийн зах зээл тогтвортой байх үндсэн нөхцөл нь улс төрийн тогтвортой байдал. Улс төрийн тогтвортой байдал бий болвол эдийн засгийн тогтвортой байдал бий болно. Эдийн засаг гэдэг өргөн хүрээтэй ойлголт. Үүн дотроо банк, санхүү, даатгал гээд явна. Бид улс төрийн хувьд дайн байлдаангүй гэдэг утгаараа тогтвортой байна. Гэхдээ хоёр жил хүрэхтэй хүрэхгүй хугацаанд Засгийн газар, Ерөнхий сайд солигдоод байхаар банкнаас гадна бусад салбарт ч нөлөөлж байна.

Төгсгөлд нь, Таныг хоёр шатлалт банкны түүхийн амьд гэрч гэж үзээд асуухад банкны хөгжлийн явцыг дүгнэх хугацаа таньд байсан байх.

Худалдаа, хөгжлийн банк анхандаа 100 хувь төрийн өмчит банк байсан. Дараа нь ажиллагсад нь 30 хувь, төр 70 хувийг эзэмшдэг болсон. Үүний дараа ажиллагсад нь 24 хувь, төр 76 хувь болсон бол одоо

93 орчим хувь нь нэг хүний эзэмшилтэй байна. Энэ мэт өмчийн өөр өөр хэлбэрүүдийн үед банкны системд ажиллалаа. Одоо Банкны холбооны Ерөнхийлөгч байх үед нэг хувьцаа эзэмшигчийн дээд хэмжээг 20 хувь гэж хязгаарлаж өгч байна. Энэ бүгдээс харахад арилжааны банкууд улам зөв зам руугаа хөгжиж байна.

Энэ явцад ямар гажуудал битгий үүсээсэй гэж Та хүсч байна вэ?

Хуулийг хэрэгжүүлэх эрх зүйн баримт бичиг, заавар журмууд олон улсын стандартын дагуу байх хэрэгтэй. Өөрсдөө шинэ юм зохиох гэж хичээх хэрэггүй. Олон улсын сайн туршлагуудыг шингээгээд, өөрсдийн гэсэн онцлогоо тусгаад явах нь зөв. Монголчилж болохгүй.

Ярилцсанд баярлалаа.

БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗЭЭЛ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ*

ББӨБГ-ын Ахлах эдийн засагч Лхагвадоржийн **Дөлгөөн**

МБГ-ын эдийн засагч Гантөмөрийн **Мөнхбаяр**

ХШГ-ын Ахлах хянан шалгагч Өлзийдэлэгийн **Тайван**

Оршил

Санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулахын тулд банк тодорхой хэмжээний эрсдэл хүлээх шаардлага тулгардаг. Өөрөөр хэлбэл, банк бусдаас хөрөнгө татан төвлөрүүлж, зээл олгох, санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулахдаа өөрийн хөрөнгийг бүрдүүлж, түүгээр эрсдэл хүлээх шаардлагатай байдаг. Банкны актив, санхүүгийн зуучлалын хэмжээ нэмэгдэх тусам тэрхүү өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдэж байдаг. Олон улсын туршлагаас үзэхэд банк активын дүнгийн тодорхой хувиар өөрийн хөрөнгийн эрсдэл хүлээх шаардлагатай байдаг.

Манай оронд “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ыг анх 1995 онд баталсан бөгөөд түүнээс хойш хэд хэдэн удаа шинэчлэн баталсан. Илүү тодорхой хэлбэл, энэхүү журмыг Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны тавдугаар сарын 23-ны өдрийн А-138 дугаар тушаалаар шинэчилэн баталсан. Журамд зааснаар банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа гэсэн хоёр үзүүлэлтээр тооцож байна.

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх нь банкны салбарын эрсдэл даах чадварыг сайжруулах, тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй хэдий ч нөгөөтэйгүүр зээлийн нийлүүлэлтийг хумих, зээлийн хүү өсөх зэрэг макро эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бий болдог. Энэхүү судалгааны ажлаар банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх нь банкны зээлийн нийлүүлэлтэд улмаар макро эдийн засагт ямар нөлөө үзүүлэхийг банкны салбарын үзүүлэлт, макро хувьсагч

бүхий нийт 10 хувьсагчтай дунд хэмжээний Бейсийн авторегрессив (BVAR) загвар ашиглан шинжиллээ.

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний эдийн засагт нөлөөлөх суваг

Банкны өөрийн хөрөнгийн хязгаарлалтын эдийн засаг болон банкны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөг тооцсон судалгааны ажлыг Зураг 1-т үзүүлсний дагуу ерөнхийд нь ангилж болохоор байна. Тодруулбал, өөрийн хөрөнгийн хязгаарлалтыг нэмэгдүүлэх нь эдийн засгийн өсөлтөд шууд бус гурван сувгаар нөлөө үзүүлнэ.

Нэгдүгээрт, банкны өөрийн хөрөнгийн өндөр хязгаарлалт нь банкны зээл, тэр дундаа эрсдэлтэй зээлийн хэмжээг бууруулах боломжтой нь зээлийн хэмжээг бууруулснаар эдийн засгийн өсөлтийг удаашруулна.

Хоёрдугаарт, банк нь шалгуур үзүүлэлтийг хангахын тулд өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх буюу алдагдсан боломжийн зардлыг өсгөх юм. Тус өөрийн хөрөнгийн зардлын өсөлтийг бүтээгдэхүүн, үйл ажиллагааны үнийг нэмэгдүүлэх буюу зээлийн хүү, хураамжийг нэмэгдүүлэх замаар нөхөх юм. Энэ нь цаашлаад зээлдэгчийн эргэн төлөлтийн ачааллыг ихэсгэж зээлийн эрсдэлийг нэмэгдүүлэхээс гадна зээлийн эрэлтийг сааруулснаар эдийн засагт сөрөг нөлөө үзүүлнэ.


Сүүлийн суваг буюу өөрийн хөрөнгийн хязгаарлалтыг сайжруулснаар үүсэх давуу тал нь банкны салбарын дархлааг нэмэгдүүлэх, тогтвортой байдлыг сайжруулах юм.

* Энэхүү судалгаа нь бүрэн эхээрээ “Мөнгө, Санхүү, Баялаг сэтгүүлийн 2020 оны 9 дүгээр сарын 21 дэх дугаарт хэвлэгдсэн болно.

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ ба зээлийн нийлүүлэлт

Манай банкны системийн өөрийн хөрөнгө болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 2010 оноос 2020 оны 2 дугаар сарыг хүртэлх байдлаар Зураг 2-т харууллаа.

Зураг 1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт



Эх сурвалж: Монголбанк

Зураг 2. Өөрийн хөрөнгийн харьцаа, зээлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Энэхүү судалгаанд өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр 1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцааны үзүүлэлтийг төлөөлүүлж авсан болно. Нийт актив нь эрсдэлээр жигнэсэн активтай санхүүгийн ойлголтын хувьд нэг утгатай, эдийн засгийн агуулгаараа давхцах учир энэхүү үзүүлэлтийг тооцохдоо нийт активын дүнг авч, үнэлгээнд ашигласан нь судалгааны үр дүнг өөрчлөхгүй болох нь Зураг 2-оос харагдаж байна. Түүнчлэн зээлийн өсөлт ба өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн хувьд сөрөг хамаарал ажиглагдаж байгаа бөгөөд өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх нь банкуудын зээлийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэх талтай юм.

Бейсийн вектор авторегрессив (BVAR) загварын үнэлгээ

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийн өөрчлөлт нь макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдэд хэрхэн нөлөө үзүүлдгийг шинжлэхийн тулд BVAR загварын үнэлгээг гүйцэтгэж хариу үйлдлийн функцийг тодорхойлсон. BVAR загварын үнэлгээгээр макро эдийн засаг болон банкны секторын хувьсагч хоорондын хамаарлыг онолын хүрээнд хэт олон бүтцийн хязгаарлалт тавихгүйгээр шинжлэх боломжтой юм.

Өөрийн хөрөнгийн шокийн нөлөө

Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний шокийн банк болон макро эдийн засгийн засгийн хувьсагчид үзүүлэх нөлөөг судалж хариу үйлдлийн функцийг тодорхойллоо. Тус шокийн нөлөөг танихдаа Cholesky буюу дарааллын таних аргыг ашигласан. Хариу үйлдлийн функц нь шокийн дараах хариу үйлдлийн постериор дундаж болон итгэх завсартайгаар (68 хувь) дүрслэгдсэн. Хэрэв итгэх завсар тэгийг агуулж байгаа тохиолдолд тухайн хугацааны үед статистикийн хувьд ач холбогдолгүй болохыг илтгэнэ.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шокод үзүүлж буй хариу үйлдлийн функцээс харахад судлагдсан байдлын хэсэгт тодорхойлогдсон зээлийн болон зардлын сувгийн нөлөө аль аль нь ажиглагдаж байна.

Зээлийн сувгийн нөлөө: Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эерэг шок нь банкны зээлийн нийлүүлэлтийг тэр дундаа иргэдийн зээлийн нийлүүлэлтийг бууруулах нөлөөтэй

байна. Энэ нь банк зээлийн багцдаа өөрчлөлт оруулж эрсдэл харьцангуй өндөртэй иргэдийн хэрэглээний болон бизнесийн зээлийн нийлүүлэлтийг бууруулах хандлагатай гэсэн панель үнэлгээний үр дүнтэй нийцтэй гарч байна.

Ингэснээр зээлийн нийлүүлэлт хумигдах нь бодит эдийн засагт сөргөөр нөлөөлөх ба эдийн засгийн өсөлт саарч улмаар зээлийн чанар муудах эрсдэлийг дагуулна. Зээлийн эрсдэл нэмэгдэх нь зээлийн хүүг өсөхөд нөлөөлнө. Системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн нийт активд эзлэх хувь 1 хувиар нэмэгдэхэд зээлийн нийлүүлэлтийг дөрвөн улирлын дараагаар хамгийн ихдээ 4 хувиар бууруулах улмаар ДНБ-ий өсөлтийг хамгийн ихдээ 1.5 хүртэл хувиар бууруулах нөлөө үзүүлдэг байна.

Зардлын сувгийн нөлөө: Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх нь банкуудад өртөг өндөртэй нэмэлт эх үүсвэрийн эрэлтийг бий болгоно. Энэ нь өөрийн хөрөнгийн эх үүсвэрийн зардлыг өсгөж улмаар зээлийн хүүг нэмэгдүүлдэг [8]. Тухайлбал Kashyar [17] болон Baker [3] нарын судалгаагаар банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлага 1 нэгж хувиар өсөхөд зээлийн хүү дунджаар 2.5-4.5 болон 6-9 хувиар өсдөг гэсэн үр дүн гарчээ. Харин манай орны хувьд энэ нь харьцангуй бага буюу 4-5 улирлын дараа зээлийн хүү хамгийн ихдээ 0.3 нэгж хувиар өсөх үзүүлэлттэй байна. Улмаар зээлийн хүүний өсөлт нь зээлийн эрэлтийг бууруулж бодит эдийн засагт сөргөөр нөлөөлнө.

Түүнчлэн зээлийн хүүний өсөлт нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлж чанаргүй зээлийг өсгөх бөгөөд санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх талтай. Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх нь зээлийн нийлүүлэлтийг бууруулах хэдий ч банкуудын ашигт ажиллагаанд үзүүлэх сөрөг нөлөө ажиглагдахгүй байна. Иймд өндөр өртөг бүхий нэмэлт хөрөнгийн зардал нь хүүний маржин тогтмол үед зээлийн хүүний өсөлтөөр тайлбарлагдаж байх талтай.

Дүгнэлт

Энэхүү судалгааны ажлаар банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний өөрчлөлт нь зээлийн нийлүүлэлтэд хэрхэн нөлөөлөх талаар судаллаа. Шинжилгээнд 2009 оноос хойш үйл ажиллагааг тогтмол явуулж буй 11 банкны тоон мэдээллийг ашиглаж панель үнэлгээг гүйцэтгэсэн.

Түүнчлэн Бейсийн вектор авторегрессив аргачлалд тулгуурлан макро эдийн засагт үзүүлэх нөлөө, тэдгээрийн дамжих сувгийн талаар авч үзлээ. Тус судалгааны үр дүнгээс дараах дүгнэлт хийж болохоор байна.

Панель үнэлгээний үр дүнгээр банкны хувьд өөрийн хөрөнгийн хүрэлцээг 1 нэгж хувиар нэмэгдүүлэхэд нийт зээлийн өсөлт дунджаар 0.3 нэгж хувиар саарч байна. Харин иргэдийн (хэрэглээний болон бизнесийн) зээлийг бизнесийн зээлтэй харьцуулахад дунджаар 0.11 нэгж хувиар илүү бууралттай байна.

Жижиг банкны хувьд өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх нь нийт зээл тэр дундаа иргэдийн зээлийн өсөлтөд хамгийн хүчтэй нөлөөлж байгаа бол, том болон дунд банкны хувьд төдийлөн нөлөө үзүүлэхгүй буюу үнэлгээний үр дүн статистикийн хувьд ач холбогдолгүй байна.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шоконд үзүүлж буй хариу үйлдлийн функцийг шинжилгээгээр зээлийн болон зардлын сувгийн нөлөө аль аль нь ажиглагдах хандлагатай байна. Тухайлбал, өөрийн хөрөнгийн хүрэлцээний эерэг шок нь банкны зээлийн нийлүүлэлтийг, тэр дундаа иргэдийн зээлийн нийлүүлэлтийг бууруулах нөлөөтэй байна. Ингэснээр зээлийн нийлүүлэлт хумигдаж бодит эдийн засгийн идэвхжилийг сулруулан улмаар зээлийн хүүг өсөхөд нөлөөлнө.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээг сайжруулах нь банкны салбарын дархлааг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадавхийг сайжруулах, улмаар урт хугацаанд санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад чухал нөлөөтэй. Ингэснээр банкны тогтвортой тогтолцоо бүрдэж, эдийн засгийн урт хугацааны өсөлтийг дэмжих юм.

Цаашид банкны салбарын бүтэц, тогтолцооны хувьд зохистой өөрчлөлт, шинэчлэлийг хийх нь эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдалд үзүүлэх урт хугацааны нөлөөний талаар нарийвчлан авч үзэх нь зүйтэй юм. Түүнчлэн өөрийн хөрөнгийн хязгаарлалт буюу банкны салбарын дотоод шокийн нөлөөг банкны салбараар өргөтгөсөн Динамик, Стохастик Ерөнхий Тэнцвэрийн загварт тулгуурлан шинжлэх нь аргагүйн хувьд илүү давуу талыг олгох бөгөөд үр дүнг харьцуулах боломжтой.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ, ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНД ОРОЛЦОХОД АНХААРАХ АСУУДЛУУД



● Хөрөнгө оруулалтын зорилго, төрөл

Хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг олох, хөрөнгөө өсгөх зорилгоор тодорхой нэг хөрөнгөд мөнгөө байршуулахыг хэлнэ. Хөрөнгө оруулагчид зорилгодоо хүрч хөрөнгийнхөө үнэ цэнийг өсгөж, ашиг олох боломж байдаг хэдий ч хөрөнгө оруулалт нь ашиггүй болж, хөрөнгө нь үнэ цэнээ алдах тохиолдол ч цөөнгүй бий.

● Хөрөнгө оруулалтын төрөл

- ЗГ-ын үнэт цаас
- Хадгаламжийн сертификат
- Хадгаламжийн данс
- Хувьцаа
- Бонд
- Бусад (Таваар, үл хөдлөх хөрөнгө)

● Хөрөнгө оруулалт хийхэд хэр их мөнгө хэрэгтэй вэ?

Хөрөнгө оруулалт хийхэд шаардлагатай хөрөнгийн доод хэмжээ гэж байхгүй. Жишээлбэл, та 5000 төгрөгтэй бол 100 төгрөгийн үнэтэй 50 хувьцаа авах боломжтой.

● Хувьцааны хөрөнгө оруулалт

Хувьцаа нь компанийн тодорхой хэсгийг эзэмших эрх юм. Жишээлбэл, та нийт 10,000 ширхэг хувьцаатай компанийн 100 ширхэг хувьцааг эзэмшдэг гэвэл тэр компанийн 1%-н эзэн гэсэн үг. Хувьцаанд хөрөнгө оруулах нь дараах давуу талуудтай. Үүнд:

- Хувьцааны үнэ цэнэ өсөх
- Ногдол ашиг хүртэх
- Хөрвөх чадвар сайн
- Саналын эрх

● Энгийн хувьцаа

Зах зээл дээр нийтэд санал болгож байгаа, саналын эрхтэй хувьцааг энгийн хувьцаа гэнэ. Хувьцаа бол компанийн дүрмийн сан буюу өөрийн хөрөнгийг бүрдүүлдэг санхүүгийн хэрэгсэл юм. Ногдол ашгийг харин компанийн цэвэр ашгаас төлдөг бөгөөд компанийн төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-өөс хуваарилах ногдол ашгийн хэмжээг баталдаг.

● Давуу эрхийн хувьцаа

Та энгийн хувьцаа худалдан авахын оронд давуу эрхийн хувьцаа худалдан авч болно. Давуу эрхийн хувьцаа бол энгийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг олгохоос өмнө ногдол ашиг хүртэх эрхийг эзэмшигчдээ олгодог хувьцааны нэг төрөл юм.

● Үнэт цаасны талаарх мэдээллийн эх сурвалжууд

- Интернэт
- Сонин, мэдээллийн программ
- Бизнесийн тогтмол хэвлэл
- Засгийн газрын хэвлэл
- Компанийн тайлан
- Хөрөнгө оруулагчдад үзүүлэх үйлчилгээ ба сонин



● **Үнэт цаасны компани**

Үнэт цаасны компани гэдэг нь харилцагч буюу иргэд, ААН-үүдэд Хөрөнгийн бирж дээрээс хувьцаа, бонд худалдан авахад зуучилдаг мэргэжлийн байгууллага юм. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа Үнэт цаасны компаниуд Брокер, Дилер, Андеррайтер болон Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй байдаг.

● **Үнэт цаасны арилжаанд хэрхэн орох вэ?**

Монголын хөрөнгийн бирж дээр ажлын өдөр бүр өглөө 10:00-13:00 цагийн хооронд үнэт цаасны арилжаа явагддаг бөгөөд та хувьцаа, бонд худалдан авах, худалдах замаар энэхүү арилжаанд оролцох боломжтой. Үнэт цаасны арилжаанд оролцохын тулд та:

- Үнэт цаасны арилжаанд зуучлах үүрэг бүхий үнэт цаасны компани /брокер/-д хандан үнэт цаасны арилжааны дансаа нээлгэсэн байх шаардлагатай.
- Данс нээлгэсний дараа брокерын компанидаа үнэт цаас худалдах эсвэл худалдаж авах захиалгаа өгнө.
- Брокер нь таны өгсөн захиалгыг хөрөнгийн биржийн арилжааны системд оруулдаг.

● **Брокерийн үйлчилгээ**

Харилцагчийн нэрийн өмнөөс, түүний захиалгын дагуу үнэт цаас худалдах, худалдан авах үйл ажиллагаа юм.

● **Initial Public Offering- Анхдагч зах зээлийн арилжаа /IPO/**


Энэ нь үнэт цаас гаргах үйл ажиллагаа нь хөрөнгө хуримтлуулах, хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгыг агуулж байдаг.

● **Үнэт цаасны зах зээлд хөл тавихад анхаарах зүйлс**

- Шинэ мэдлэг, мэдээллээр өөрийгөө үргэлж цэнэглэ – Хөрөнгө оруулалтын үндсэн зорилго нь өгөөж хүртэх хэдий ч мөнгө олохын төлөө бүү яар.
- Тэвчээртэй, тууштай бай – Алдагдал хүлээх үедээ болон ашиг олох үедээ сэтгэлзүйгээ зөв удирд
- Алдагдал хүлээсэн бол шалтгааныг нь олж, гаргасан алдаанаасаа суралц – хөрөнгө оруулалтын багцаа тухай бүр шинэчил.
- Өөрийн хэрэглээнээс илүү гарсан мөнгөөр арилжаанд оролц – Хэзээ ч бүү зээл авч хөрөнгө оруулалт хий.

● **Бүх өндгөө нэг сагсанд бүү хий**

Бүх өндгөө нэг сагсанд бүү хий. Өөрөөр хэлбэл, янз бүрийн салбарт хөрөнгө оруулалтын өөр өөр төрөлд мөнгөө тараан хуваарилах замаар хөрөнгө оруулах буюу мөнгөө нэг ижил чиглэлд хөрөнгө оруулахгүй байх нь зүйтэй. Төрөлжүүлэлтийн гол зорилго нь зарим хөрөнгө оруулалтаас хүлээсэн алдагдлыг амжилттай хөрөнгө оруулалтын ашиг, орлогоор нөхөх боломжийг бүрдүүлэхэд оршино. Өөрөөр хэлбэл, эрсдэл ихтэй болон багатай хөрөнгө оруулалтын тэнцвэрийг хангах сайн арга юм.



САНХҮҮГИЙН
БОЛОВСРОЛ